



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 9 (342)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Ерөнхий төлөвлөгөө батлах тухай*
(Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө)

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2004 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2004 оны гуравдугаар сарын 5 № 9 (342)

Гарчиг

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

112. Ерөнхий төлөвлөгөө батлах тухай

Дугаар 264

145

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 12 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 264

Улаанбаатар хот

Ерөнхий төлөвлөгөө батлах тухай

Газрын тухай хуулийн 18.7-г үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар (Ш.БАТСҮХ)-т, уг төлөвлөгөөг эрхлэх асуудлынхаа хүрээний үйл ажиллагаанд баримталж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.

3. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан аймгуудын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг 2004-2006 онд багтаан боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах, уг ажилд шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсвийн багцаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

Монгол Улсын
Ерөнхий сайд

Н.ЭНХБАЯР

Байгаль орчны
сайд

У.БАРСБОЛД

Засгийн газрын 2003 оны 264 дүгээр тогтоолын хавсралт

УЛСЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нэгдүгээр бүлэг.

МОНГОЛ УЛСЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХЫН ӨМНӨХ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТОЙМ

1.1. Монгол орны газрын нөөц ашиглалтын одоогийн байдал

Монгол Улс дэлхийн гадаргуугийн 0.31 хувь, газрын нөөцийнх нь 1.16 хувийг эзэлсэн нутаг дэвсгэртэй. 2000 оны байдлаар дэлхийн нэг хүнд дунджаар 2.7 га газар ногдож байхад Монгол Улсын нэг иргэнд 65 га газар ногдож байна. Монгол орны сүүлийн 40 жилийн нийгмийн байгууламж, түүний социаль ба эдийн засгийн хүчин зүйлс нь газар

ашиглалтын зориулалт, бүтэц, дүр төрх, төлөв байдалд тоо, чанарын асар их өөрчлөлт оруулж байна.

Улсын нийт газар нутгийн 83.2 хувийг хөдөө аж ахуйн газар, 5.1 хувийг хот, тосгон, бусад суурины газар, 8.2 хувийг ойн сангийн газар, 1.4 хувийг усан сангийн газар, 4.1 хувийг ашиглалтгүй болон ашиглахад бэрхшээлтэй газар тус тус эзэлдэг.

Газрын нөөцийн орон зайн болон биочадавхи, хэвлийн эрдэс баялгийн нөөц нь тус улсын нийгэм-эдийн засгийн хөгжилд нөлөө бүхий хүчин зүйлс болсоор байна. Энэ нь тус улсын хөгжил байгалийн бэлэн нөөцөд түшиглэх үзэл баримтлалаар хөгжиж ирсэнтэй холбоотой юм.

Газрын нөөцийн хувьд улсын нийт нутаг дэвсгэрийн 55 хувийг эзэлж буй эдийн засгийн гол бүс болох төвийн бүсэд тариалангийн газрын 73 хувь, ойгоор бүрхэгдсэн талбайн 78 хувь, хот, суурин газрын 64 хувь, хадлангийн газрын 60 гаруй хувь нь тус тус хамрагдаж байгаа нь байгалийн нөөцийн хувьд дээрх бүс нь илт давуу байдалд байгааг харуулж байна.

Улсын хэмжээнд:

A/Бэлчээрийн газар

Байгалийн бэлчээрт тогтвортой ашиглаж байгаа газар 112-113 сая орчим га бөгөөд бэлчээрийн даац нь хонин толгойд шилжүүлснээр зун-намарт 81.1 сая, өвөл-хаварт 59.4 сая мал агуулах чадвартай.

Ашиглалтын буруу үйл ажиллагаа, байгальцаг уурын хүчин зүйлс дангаар болон хавсарсан хэлбэрээр үйлчилж доройтуулсан бэлчээр 22 сая га болоод байгаа нь бэлчээрийн доройтолтой тэмцэх ажил газрын менежментийн үйл ажиллагааны чухал хэсэг болохыг харуулж байна.

Доройтолд орсон бэлчээрийн талбай

Хүснэгт №1

| Доройтлын хэлбэр | Талбай /мян.га/ |
|------------------------------|-----------------|
| Дунд зэрэг талхлагдсан | 6235.8 |
| Их талхлагдсан | 2672.5 |
| Хортон мэрэгчдэд нэрвэгдсэн | 10716.1 |
| Элсний нүүлтэд орж цөлжсөн | 906.2 |
| Усны эвдрэлд орсон | 45.5 |
| Автогенийн нөлөөнд автагдсан | 1839.2 |
| Дүн | 22415.3 |

Бэлчээр талхлагдах үндсэн шалтгаан нь бэлчээрийн усан хангамж муудсанаас болж нэг худаг, гол, горхи бараадан бөөгнөрөх, уламжлалт мал маллагааны 4 улирлын сэлгээт нүүдлээс өвөл-хавар, зун-намарт гэсэн 2 сэлгээт нүүдэлд шилжсэн явдал гэж үзэж байна.

Бэлчээрийн талхлагдалт нь бэлчээрийн нутаг дэвсгэрийг жигд ачаалалтай ашиглахгүй байгаагаас голлон шалтгаалж байгаа юм. Нийт сумын төвүүдийн ойролцоо 5 км орчим радиустай бэлчээр их талхлагдсан, түүнээс цааш 10 км хүртэл дунд зэргийн талхлагдсан байгаа нь судалгаагаар тогтоогджээ. Түүнчлэн элсний нүүлт, цөлжилтийн процесс нэлээд нэмэгдэх хандлагатай болсон байна.

Ажиглалтаас үзэхэд элсний нүүлт, цөлжилтийн процесс нь дараахь хэлбэрээр явагдаж байна:

1/томоохон доёцог элснээс нарийн ширхэгтэй торгон элс салхины нөлөөллөөр нүүж, элсгүй талбайг бүрхэж, элсэн давхарга үүсгэж байна. Элсний ийм нүүлт Завхан аймгийн баруун сумд (Сантмаргац, Цэцэн-Уул гэх мэт), Увс аймгийн зарим сумд, Борхярын элсний орчмоор эрчимтэй байна;

2/байгалийн ба хүний хүчин зүйлийн нөлөөллөөр бэлчээрийн ургамлан бүрхүүл бүрэн үгүй болж, цөлийн ба цөлөрхөг зэргийн хөнгөн хөрс аяндаа элсжих замаар цөлжилт явагдаж байна.

Цөлжилт явагдаж байгаа газар цаг ямагт элсэн довонгууд үүсдэг. Цөлжилт их явагдаж байгаа газрын сонгомол жишээнд Баянхонгор аймгийн Шинэжинст, Баян-Өндөр, Баянлиг сумдын нутаг орж байна.

Манай орны хуурай хээр, цөлөрхөг хээр, тал хээр нутгийн бэлчээрийн талхлагдлын гол шалтгаан нь үлийн цагаан оготно болжээ. Үлийн цагаан оготно тархсан бэлчээр улсын хэмжээгээр 10.7 сая га байна. Оготно нь ургамлан бүрхүүл болсон үндсийг нь устгадгаараа эдийн засгийн болон экологийн давхар хохирол учруулдаг.

Б/Тариалангийн газар

1959 онд атар газар эзэмшсэн үеэс эхлэн тариаланд тохиромжтой 1 сая 340 мянган га газрыг хагалжээ. Үүнээс дээд газрын шийдвэрээр /Байгаль орчны хяналтын улсын хорооны 1992 оны 20 дугаар тогтоолоор/ цаашид тариаланд ашиглах боломжгүй гэж үзсэн 113.3 мянган га газрыг тариалангийн газраас хасаж бэлчээрт шилжүүлснээр 1 сая 226 мянган га эргэлтийн талбайтай болсон байна.

Сүүлийн 10-аад жилд 423 мянган га талбай атаржуулснаар тариалангийн талбайн 60 гаруй хувь нь ашиглагдаж байгаа юм.

В/Ойн сангийн газар

Энэ ангиллын газар 18.3 сая га байгаагийн 12.9 сая га нь ойгоор бүрхэгдсэн газар байгаа бөгөөд

үүний дотор 2.0 сая га нь загаар бүрхэгдсэн газар байна.

1990 оныг хүртэл жилд дунджаар 2.2 сая м², 1990-2000 онд 800 мян. м² мод бэлтгэж байсан бол 2000 онд 520 мян. м², 2001 онд 593.2 мян. м² мод бэлтгэжээ. Түлшинд 400 мян м² мод, 1000 орчим тн заг хэрэглэж байна гэсэн тооцоо байдаг.

Сүүлийн таван жилийн дүнгээр улсын хэмжээгээр ойн түймэрт 6.4 сая га талбай өртсөн байна. 2001 онд улсын хэмжээгээр 8000 га талбайд ойн нөхөн сэргээлтийн ажил хийгдэж, 1991 оноос хойш нийтдээ 3271 га ойжуулсан талбайг улсын ойн санд шилжүүлжээ. 1971 оноос хойш ойжуулсан талбай мод бэлтгэсэн нийт талбайн 30 орчим хувийг эзэлж байна.

Г/Усан сан бүхий газар

Улсын хэмжээгээр байгалийн ил задгай усны дор болон мөнх цас, мөсөн голын дор нийт 2.2 сая га газар байгаа бөгөөд түүнээс жилдээ 33 км³ ус, түүний 6.1-ийг нь газрын доорхи уснаас ашиглаж болох нөөцтэй байна.

Д/Хот, тосгон, бусад суурины газар

Суурьшлын бүсийн 47.5 мян га нь барилга байгууламжийн доорхи газар, 20.0 мян га нь гэр хорооллын газар, 300.0 мян га нь нийтийн

ашиглалтын газар, 3.8 мян га нь үйлдвэр, 47.4 мян га нь уурхайн газар, 8.4 мян га нь бусад газар байна.

Улсын хэмжээний нийт хот, суурины газраас зөвхөн хот, аймгийн төвийн тэг гуртгит одоогоор 162.1 мян га газар байгаагийн 32.5 мян га нь барилга байгууламжийн доорхи газар, 10.3 мян га нь гэр хорооллын газар, 101.3 мян га нь нийтийн ашиглалтын газар, 2.4 мян га нь үйлдвэр, 8.4 мян га нь уурхайн газар, 7.1 мян га нь бусад газарт хамрагдсан байна.

Хоёрдугаар бүлэг.

ГАЗРЫН НӨӨЦ АШИГЛАЛТЫН ТӨЛӨВӨЛТ

Монгол орны газар нутгийн нөхцөл

Монгол орны газрын нөөцийн нутаг дэвсгэрийн ялгааг илрүүлэн дүн шинжилгээ хийхийн тул бүс нутгуудыг ялгаж, түүнийг байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлөөр нь мужуудад, хотгор гүдгэрийн ялгаа, түүнтэй уялдан-илрэх газар ашиглалтын онцлогийг харгалзан тойргуудад тус тус хуваалаа. Хангай, говь, хээр тал хэмээх уламжлалт 3 бүс нутаг, түүний доторхи 12 муж, 31 тойргийг ялгаж цаг уур, хөрс ургамал экологи, хотгор гүдгэр, газар ашиглалтын онцлогт дүн шинжилгээ өгөв (зураг 1).

Бүс нутгийн мужуудын нутаг дэвсгэрийн хэмжээ

Хүснэгт №2

| № | Бүс | Мужийн нэр | Мужийн нийт талбай /мян.га/ | Эзлэх хувь |
|----|-----------------|--|-----------------------------|------------|
| 1 | Хангайн бүс | Хөвсгөл орчмын өндөр уул, тайга хосолсон муж | 910,3 | 5,82 |
| 2 | | Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон муж | 1883,2 | 12,00 |
| 3 | | Орхон-Сэлэнгийн савын ойт хээрийн муж | 1237,2 | 7,91 |
| 4 | | Хэнтийн нурууны тайгын муж | 1190,3 | 7,64 |
| 5 | | Монгол Алтайн өндөр уулын муж | 1210,7 | 7,74 |
| 6 | | Их Хянганы салбар уулсын муж | 70,4 | 0,45 |
| 7 | Говийн бүс | Алтайн ар говийн цөлөрхөг муж | 1639,0 | 10,48 |
| 8 | | Говийн Алтайн уулсын муж | 603,7 | 3,86 |
| 9 | | Алтайн өвөр говийн цөлийн муж | 1673,6 | 10,70 |
| 10 | | Дорнод говийн цөлөрхөг муж | 2653,4 | 17,06 |
| 11 | Тал хээрийн бүс | Дундад халхын болон дорнод монголын талархаг хээрийн муж | 2309,8 | 14,71 |
| 12 | | Дорнод монголын цав толгодорхог нам уулс бүхий хээрийн муж | 255,0 | 1,63 |
| | | Нийт талбай | 156411,6 | 100 |

Газар нутгийн эдгээр муж, тэдгээрийн доторхи тойрог нь яваандаа улс орны хөгжлийн явцад газар ашиглалтын нутаг дэвсгэрийн бүтэц ялгаран тогтох газар зүйн орон зай бөгөөд газар ашиглалтыг төлөвлөх, зохион байгуулах, газрын нөөцөд экологи-эдийн засгийн чадавхийн үнэлгээ өгөх зэрэгт голлох үүрэг гүйцэтгэх болно.

2.1. ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

Хөдөө аж ахуйн газрын төлөвлөлт

Хөдөө аж ахуйн гаралтай, экологийн хувьд цэвэр хүнсний бүтээгдэхүүний дотоодын хангамжийг тодорхой үе шаттайгаар нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай газрын эрэлт нийлүүлэлтийг тооцоолж, хэрэгцээт газрын байршлыг бүслэн төлөвлөх аргыг баримтлав /зураг 2/.

Төлөвлөлтөөр хөдөө аж ахуйн газарт орох өөрчлөлт /мян га-гаар/

Хүснэгт №3

| | Тариалан | Атаржсан газар | Хадлан | Бэлчээр | Хөдөө аж ахуйн бусад газар | Бүтл |
|----------|----------|----------------|--------|----------|----------------------------|----------|
| 2002 онд | 752,1 | 423,2 | 1972,9 | 126978,4 | 47,3 | 130173,9 |
| 2023 онд | 1175,0 | 7,5 | 1972,9 | 113599,4 | 47,3 | 116802,1 |
| Өөрчлөлт | +422,9 | -415,7 | - | -13379 | - | -13371,8 |

2.1.1. Тариалангийн газрын төлөвлөлт

2002 оны байдлаар 752 мян га-д тариалан эрхэлж, үүнээс 423 мян га нь атаржсан байдалтай байна. Ойрын 20 жилд тариалангийн газрын хэрэгцээг хангахад шинээр атар газар эзэмших шаардлагагүй бөгөөд өнжөөсөн, атаржуулсан газрыг дахин эргэлтэд оруулах замаар тариалангийн газрын эрэлтийг хангах боломжтой. Үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамлын

хэрэгцээг хангахын тулд 2023 оны түвшинд 1175.0 мян га эргэлтийн талбайтай байх шаардлагатай

2023 он гэхэд 500-550 мян га-д үр тариа, 13-15 мян га-д төмс, хүнсний ногоо, 150 мян га-д тэжээлийн ургамал тариалахад гурилын хэрэгцээний 75 хувь, төмс, хүнсний ногоо, сүүний чиглэлийн жижиг, дунд хэмжээний фермүүдийн дарш, ногоон тэжээлийн хэрэгцээг бүрэн хангах юм. Нийт эргэлтийн талбайн 1/3 буюу 390-400 мян га талбайг уриншилж байхаар тооцно.

Тариалангийн газрын төлөвлөлт /мянган га-гаар/

Хүснэгт №4

| Газар нутгийн тойргийн индекс | Тариалангийн талбайн нөөц | Тариалах талбай | | Үүнээс | | | | | |
|-------------------------------------|---------------------------|-----------------|-------|----------|-------|---------------------|------|----------------|------|
| | | | | Үр тариа | | Төмс, хүнсний ногоо | | Даршин ургамал | |
| | | 2013 | 2023 | 2013 | 2023 | 2013 | 2023 | 2013 | 2023 |
| 1 ХО-1 | 101.0 | 76.2 | 92.9 | 32.6 | 32.6 | 6.2 | 8.2 | 37.4 | 52.1 |
| Хот орчмын нутаг | 101.0 | 76.2 | 92.9 | 32.6 | 32.6 | 6.2 | 8.2 | 37.4 | 52.1 |
| 2 ХУ-1 | 16.6 | 0.5 | 0.5 | | | 0.5 | 0.5 | | |
| 3 ХУ-2 | 378.1 | 253.3 | 253.3 | 253.3 | 253.3 | | | | |
| 4 ХУ-3 | 6.8 | 0.5 | 0.5 | | | 0.5 | 0.5 | | |
| 5 ХУ-4 | 6.1 | 0.5 | 0.5 | | | 0.5 | 0.5 | | |
| 6 ХУ-5 | 11.9 | 1.0 | 1.0 | | | 1.0 | 1.0 | | |
| 7 ХУ-6 | 220.2 | 147.6 | 147.6 | 147.6 | 147.6 | | | | |
| 8 ХУ-7 | 93.9 | 1.0 | 1.0 | | | 1.0 | 1.0 | | |
| 9 ХУ-8 | 67.2 | 0.5 | 0.5 | | | 0.5 | 0.5 | | |
| 10 ХУ-9 | 78.3 | 53.5 | 53.5 | 52.5 | 52.5 | 1.0 | 1.0 | | |
| 11 ХУ-10 | 21.0 | 14.4 | 14.4 | 14.1 | 14.1 | 0.3 | 0.3 | | |
| Хангай Жэнтийн уулархал нутаг | 900.1 | 472.7 | 472.7 | 467.4 | 467.4 | 5.3 | 5.3 | | |

| | | | | | | | | | |
|-------------------------|------|--------|-------|-------|-------|-------|------|------|-----------|
| 12 | АУ-1 | 2.9 | | | | | | | |
| 13 | АУ-2 | 7.3 | 0.2 | 0.2 | | 0.2 | 0.2 | | |
| 14 | АУ-3 | 0.8 | 0.2 | 0.2 | | 0.2 | 0.2 | | |
| Алтайн уулархаг нутаг | | 10.9 | 0.4 | 0.4 | | 0.4 | 0.4 | | |
| 15 | УТ-1 | 49.4 | 0.3 | 0.3 | | 0.3 | 0.3 | | |
| 16 | УТ-2 | 4.2 | | | | | | | |
| 17 | УТ-3 | 0.4 | | | | | | | |
| 18 | УТ-4 | 0.1 | | | | | | | |
| 19 | УТ-5 | 0.3 | | | | | | | |
| Уулархаг талархаг нутаг | | 54.4 | 0.3 | 0.3 | | 0.3 | 0.3 | | |
| 20 | Т-1 | 61.1 | 0.3 | 0.3 | | 0.3 | 0.3 | | |
| 21 | Т-2 | 9.2 | 0.2 | 0.2 | | 0.2 | 0.2 | | |
| 22 | Т-3 | 38.8 | 0.3 | 0.3 | | 0.3 | 0.3 | | |
| Тал нутаг | | 109.0 | 0.8 | 0.8 | | 0.8 | 0.8 | | |
| УЛСЫН ДУН | | 1175.4 | 550.4 | 567.1 | 500.0 | 500.0 | 13.0 | 15.0 | 37.4 52.1 |

2002 оны байдлаар улсын хэмжээгээр мян.га байгаагийн гуравны нэг нь Төв аймагт, 14 элэгдэл, эвдрэлд орж, нөхөн сэргээлт хийх хувь нь Булган аймагт, 8.5-8.7 хувь нь Дорнод, шаардлагатай болсон тариалангийн талбай 458.8 Сэлэнгэ, Завхан аймгуудад тус тус байна.

Элэгдэл, эвдрэлд орсон нөхөн сэргээлт хийх шаардлагатай тариалангийн талбай /мян.га-гаар/

Хүснэгт №5

| Аймаг | 2002 оны байдлаар нөхөн сэргээлт хийх шаардлагатай | 2003-2013 ойн прогноз | | | | 2014-2023 ойн прогноз | | | |
|-------------|--|-----------------------|---------------------------------|--|---|-----------------------|----------------------------------|--|---|
| | | Нөхөн сэргээлт хийх | Валаргах зорилого, сая тугрумг* | Нэмж элэгдэл, эвдрэлд орох магадлалтай | 2013 ойн эцэст нөхөн сэргээлт хийх шаардлагатай | Нөхөн сэргээлт хийх | Валаргах зорилого, сая тугрумг** | Нэмж элэгдэл, эвдрэлд орох магадлалтай | 2023 ойн эцэст нөхөн сэргээлт хийх шаардлагатай |
| Архангай | 1.2 | 1.2 | 61.9 | | | | | | |
| Баян-Өлгий | 0.1 | 0.1 | 6.2 | | | | | | |
| Баянхонгор | | 0.3 | 15.5 | 0.3 | | 0.3 | 15.5 | 0.3 | |
| Булган | 64.0 | 21.3 | 1100.8 | | 42.7 | 21.3 | 1100.8 | | 21.3 |
| Говь-Алтай | | 1.1 | 56.8 | 1.1 | | 1.1 | 56.8 | 1.1 | |
| Говьсүмбэр | | | | | | | | | |
| Дархан-Уул | 0.3 | 0.3 | 15.5 | | | | | | |
| Дорнод | 40.5 | 18.2 | 939.9 | 11.0 | 33.7 | 18.2 | 939.9 | 11.0 | 26.1 |
| Дорноговь | | 0.1 | 5.2 | 0.1 | | 0.1 | 5.2 | 0.1 | |
| Дундговь | | | | | | | | | |
| Завхан | 39.1 | 13.9 | 717.4 | 8.0 | 33.2 | 13.9 | 717.4 | 8.0 | 27.3 |
| Орхон | 0.5 | 0.5 | 25.8 | | | | | | |
| Өвөрхангай | 28.1 | 9.7 | 501.2 | 5.0 | 23.3 | 9.7 | 501.2 | 5.0 | 18.6 |
| Өмнөговь | | | | | | | | | |
| Сүхбаатар | 7.8 | 6.1 | 313.3 | 5.5 | 7.3 | 6.1 | 313.3 | 5.5 | 6.7 |
| Сэлэнгэ | 40.0 | 13.3 | 687.1 | | 26.6 | 13.3 | 687.1 | | 13.3 |
| Төв | 141.5 | 51.4 | 2651.8 | 40.0 | 130.1 | 51.4 | 2651.8 | 40.0 | 119.7 |
| Увс | 35.4 | 17.4 | 896.8 | 10.0 | 28.0 | 17.4 | 896.8 | 10.0 | 20.6 |
| Ховд | 2.1 | 1.3 | 64.7 | 1.1 | 2.0 | 1.3 | 64.7 | 1.1 | 1.9 |
| Хөвсгөл | 27.6 | 9.2 | 474.4 | 5.0 | 23.4 | 9.2 | 474.4 | 5.0 | 19.2 |
| Хэнтий | 27.7 | 19.6 | 1011.5 | 13.0 | 21.1 | 19.6 | 1011.5 | 13.0 | 14.5 |
| Улаанбаатар | 3.0 | 1.5 | 77.4 | 1.4 | 2.9 | 1.5 | 77.4 | 1.4 | 2.7 |
| Дун | 458.8 | 186.5 | 9623.2 | 101.5 | 373.8 | 184.4 | 9513.8 | 101.5 | 291.0 |

2003-2013 онд 186.5 мян.га-д нөхөн сэргээлт хийнэ гэж тооцоход 9.6 тэрбум төгрөг буюу жил бүр 875 сая төгрөг шаардагдах юм. Цаашид газрын төлбөрийн орлогоос нөхөн сэргээлтэд зарцуулах хөрөнгө болох тариалангийн газрын хувьчлалтай холбогдож, хувь хүмүүс, компаниас гаргах хөрөнгийг мөн нэмэгдүүлэх нь зүйтэй байна.

Мөн тариалангийн эргэлтэд байгаа газрын хөрсийг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг уг газрыг өмчлөгч, эзэмшигчтэй байгуулсан газар эзэмших, ашиглах гэрээний дагуу таримлын сэлгээ, тариалан эрхлэх технологиор зохицуулна.

Голчлон хуурай хээр, талын бүсэд оршиж байгаа тариалангийн талбайнууд цаашид нэмж элэгдэл, эвдрэлд орох магадлал өндөр юм. Ойрын 10 жилд (2003-2013) нэмж 100 гаруй мян.га тариалангийн талбай элэгдэл, эвдрэлд орох магадлалтай байна. Иймээс нөхөн сэргээлтийг илүү хурдацтай хийж чадвал 10 жилийн төгсгөлд нөхөн сэргээлт хийх шаардлагатай талбайн хэмжээ буурах юм. Өөрөөр хэлбэл нөхөн сэргээлт хийх шаардлагатай талбай 2002 онд 458.8 мян.га байгаа бол 2013 онд 373.8 мян.га, 2023 онд 291.0 мян.га болно.

Тариалангийн талбайг хөрсний элэгдлээс хамгаалах уламжлалт арга хэмжээнээс гадна өндөр хөгжилтэй орнуудад хэрэгжүүлж буй цомхтгоосон, тэглэсэн, шууд тарих хэмээн нэрлэгддэг технологийг газар тариаланд тууштай нэвтрүүлэх шаардлагатай.

Тариалангийн талбайн ойн зурвас

Тариалангийн талбай хамгаалах ойн зурвас байгуулах ажигд тариалан эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг татан оролцуулах, жил бүр 100-200 км газарт ойн зурвас байгуулах шаардлагатай 1 км ойн зурвас байгуулахад 5.0 сая төг зарцуулах юм.

Тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, хувь хүмүүст жил бүр тодорхой хэмжээний тариалангийн талбайд хамгаалалтын ойн зурвасыг байгуулах ажлыг хариуцуулан өгч гүйцэтгүүлэх бодлого барих хэрэгтэй байна. Ялангуяа тариалангийн гол бүс нутагт ойн зурвас байгуулах ажлыг газар эзэмших, байгаль орчныг хамгаалах ажилтай уялдуулан заавал гүйцэтгүүлэх механизмыг бий болгох шаардлагатай гэж үзэв.

Улсын хэмжээнд жил бүр ойролцоогоор 300.0 мян.га талбайд тариалалт хийдэг гэж үзвэл тариалангийн талбай хамгаалах зурвасыг 9-10 мян.га-д хийж, хөрсний элэгдэл, эвдрэл, үржил шимийг салхинаас хамгаалах зайлшгүй шаардлага гарч байна. Харин тухайн тариалангийн талбайг эзэмшиж аж ахуй эрхэлдэг аж ахуйн нэгж өөрсдийн

хөрөнгөд тохируулан жил бүр 5-10 га ойн зурвас байгуулаад байхад тодорхой газрын талбайг хамгаалах боломжтой болох юм.

Тариалангийн талбайн 3-4 хувийг ойн зурвас эзэлж байвал уг талбай хөрс, салхины элэгдэлд орохгүй байх бүрэн үндэстэй ба 1 га талбайгаас авах ургацын хэмжээ дунджаар 20-30 хувиар нэмэгддэг гэсэн судалгаа байдаг байна. Иймд 2003-2023 онд улсын хэмжээгээр жил бүр 100-гаас доошгүй га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулах тооцоог хийв. 1 га ойн зурвасын зардал 5.0 сая төгрөг бол жил бүр 100 га-гаас доошгүй талбайд хийнэ гэвэл жилд л 500.0 сая төгрөг шаардлагатай болж байна. Энэ хөрөнгийн асуудлыг аж ахуйн нэгж, байгууллага өөрсдөө шийдвэрлэж, жил бүрийн нарийвчилсан төлөвлөгөөндөө тусгаж байх хэрэгтэй юм.

Усалгаатай газар тариалан

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт газар тариалангийн үйлдвэрлэлийн уналтыг зогсоох талаар тодорхой зорилт дэвшүүлсний дотор Газар тариалангийн үйлдвэрлэлийн уналтыг зогсоож, түүний тогтвортой хөгжих нөхцөлийг хангахад чиглэгдсэн эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлнэ", "Усалгаатай талбайн ашиглалтыг нэмэгдүүлнэ", "Ногоон хувьсгал" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ" гэж тусгажээ.

Судалгаанаас үзэхэд 1990-ээд онд инженерийн хийцтэй усалтын системийн нийт талбай 49.5 мян.га-д хүрч, үүний 87.7 хувь буюу 33.6 мян.га-д тариалалт хийж, түүнээс улсын хэмжээнд төмний 14.6 хувийг, хүнсний ногоо, жимс, жимсгөнийг 100 хувь, үр тарианы 2 хувийг тэжээлийн ургамлын 20 гаруй хувийг тус тус хураан авч байсан бол 2002 онд инженерийн хийцтэй усалтын системтэй талбайн дөнгөж 7.5 мян.га-д тариалалт хийсэн байна.

Хуурайвтар цаг ууртай, чийг тунадас дутагдалтай манай орны хурдтай газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх ялангуяа, хүнсний ногоо, жимсний аж ахуйг эрхлэх, байгалийн хадлан, тэжээлийн ургамлын найдвартай ургац авахын тулд усалгаатай тариаланг эрхлэх асуудал зайлшгүй юм.

Манай оронд баригдсан нийт усалтын системийн 30 орчим хувь нь говь, хээрийн хуурай ба нэн хуурай бүсэд байрладаг. Энэ бүсэд таримлын ургалтын хугацаанд хур тунадас маш бага унадаг, ууршилт их, усны эх үүсвэрийн нөөц бага байдаг учраас усны нөөцийг тодорхой хугацаанд хуримтлуулан нэмэгдүүлэх, зохицуулах усан сан, цөөрмүүд чухал үүрэгтэй.

140 гаруй услалтын системийн хүчин чадлыг бүрэн ашиглахад жилд нийтдээ 100.0 гаруй сая м³ ус хэрэглэх бөгөөд энэ нь улсын хэмжээний нийт ус хэрэглээний 25 орчим хувийг эзлэх болно.

Таримал ургамалд шаардлагатай чийгийн дутагдлыг зөвхөн усалгаагаар нөхөж байж сая тогтвортой ургац авах боломжтой. Эрдэм шинжилгээ, туршилт судалгааны үр дүнд таримлын усалгааг зөв аюулснаар үр тарианы ургацыг 2.0-2.5 дахин, байцааны ургацыг 4.9 дахин, төмс, сонгинын ургацыг 2.2-2.5 дахин нэмэгдүүлж болохыг нотолсон байна. Иймээс урьд өмнө ажиллаж байгаад задэрч тоногдсон усалалтын системүүдийг сэргээн шинэчилж ойрын 20 жилд 1990 оны түвшинд хүргэх шаардлагатай болоод байна.

Монгол Улсын Засгийн газар 1997 оны 199 дүгээр тогтоолоор "Ногоон хувьсгал" үндэсний хөтөлбөрийг 2004 оныг дуустал 3 үе шаттайгаар баталж, хэрэгжүүлж байна. Хөтөлбөрөөр төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, үр тариа, эмийн ургамал тарьж ургуулах, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх, хот суурингийн нийт 350 мянган өрхийн хагасаас илүү өрхийн хэрэгцээндээ тариалалт эрхэлдэг болгох, сургалт, сурталчилгааны агропаркуудыг байгуулах зэрэг зорилт тавьсныг усалгааны норм, горим технологитой уялдуулан шийдвэрлэх нь зүйтэй.

Дараахь услалтын системүүдийн хүчин чадлыг /зураг №4/ нэмэгдүүлэх, засвар, шинэчлэлтийн ажлыг хийхэд хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна:

- § Сэлэнгэ аймгийн Цагаантолгойн;
- § Өвөрхангай аймгийн Хархоринь;
- § Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Гуулингийн, Чандмань сумын Хөрхөөгийн, Цогт сумын Шугуй,Хаяа, Халуун сумын Елтонгийн;
- § Увс аймгийн Баруунтурууны болон Улаантолгойн;
- § Ховд аймгийн Голын-Адаг, Улаанхүрээ, Цагаан-Эрэг, Цагаанбургас зэрэг услалтын системүүд.

Газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглаж байсан зарим боломжтой суваг шуудууг сэргээн

засварлах, хур бороо, цасны усыг цуглуулах цөөрөм, усан санг байгуулах, улсын хэмжээнд голуудын үерийн усыг цуглуулж газар тариаланд ашиглах нэгдсэн төсөл хэрэгжүүлж боловсруулах шаардлагатай байна.

Дорноговь аймгийн Цагаанцав /нөөц нь 69120 м³/хоног/, Өмнөговь аймгийн Балгасын Улааннуур /нөөц нь 40176 м³/хоног/, Дорноговь аймгийн Бор хөөвөр дэхь /52595 м³/хоног ундргаатай/ ордуудыг хөдөө аж ахуйд, ялангуяа усалгаатай газар тариалан, жимс жимсгэний аж ахуй, хүнсний амтлагч болон гоо сайхны үйлдвэрлэлийн түүхий эд гарган авдаг ургамлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь эдийн засгийн стратегийн өндөр ач холбогдолтой байх болно. Говь, тал хээрийн бүсэд буй үйлдвэрлэлийн зэргээр нөөцийг нь тогтоосон газрын дорхи усны ордуудыг түшиглүүлэн хөдөө аж ахуйн чөлөөт бүс байгуулах боломжийг судалж үндэслэлийг боловсруулахад анхаарах шаардлагатай.

2.1.2. Бэлчээрийн газар

Хөдөө аж ахуйн газраас бүсэд зориулалтын ангилалд шилжих газар нь үндсэндээ өнөөгийн бэлчээрт тооцогдож буй газар тул төлөвлөлтийн эцэст бэлчээрийн газар бараг 14 сая гаруй га-гаар буурна.

Цөлийн бүсийн доторхи жинхэнэ цөл, хэт гандуу цөл, Хөвсгөл, Хэнтийн нурууны уулын тайгын бүслүүр, Дорнод монголын хээр талын бүсэд одоо ашиглалтгүй байгаа газрууд, Бага Хянганы бэсрэг уулс, Дэгээ-Нөмрөгийн гол, Ламын хайрхан уул, Баруун эрээний нуруу орчмын газрууд одоо бэлчээрт тооцогдож байгаа боловч цаашид бэлчээрийн ач холбогдолгүй хэвээр байх болно гэж үзлээ.

Бэлчээрийн газрын хэрэгцээг тооцоолж үзэхэд 118.6 сая га бэлчээрт 26 сая толгой малтай байх хувилбар хамгийн оновчтой нь юм.

Гэвч 2023 оны түвшинд малын бэлчээрийн тэжээлийн хэрэгцээг хангахын тулд хөдөө аж ахуйн ангиллын газар дахь бэлчээрийн газраас гадна зохих хууль тогтоомжийн дагуу бусад ангиллын газруудын зарим хэсгийг мал бэлчээрлүүлэхэд давхар ашиглах шаардлагатай.

Бусад ангиллын газраас мал бэлчээрлүүлэхэд ашиглах газрын тооцоо, бэлчээрийн хангамжийн баланс

Хүснэгт №6

| № | Бэлчээрт ашиглах болох бусад зориулалтын газрууд | Өвс ургамалт талбай /мян.га/ | Хүнээс бэлчээрт ашиглахаар тооцогдсон талбай |
|------|--|------------------------------|--|
| 1. | Авто замын зурвас газар | 313,4 | 313,4 |
| 2. | Эрчин хүчний зугам сүлжээний зурвас газар | 20,0 | 20,4 |
| 3. | Холбоо мэдээллийн зугам сүлжээний зурвас газар | 51,8 | 51,8 |
| 4. | Заг бүхий газар | 4515,3 | 4515,3 |
| 5. | УТХГН-ийн нутаг дэвсгэр | 12430,6 | 9572,0 |
| 6. | Төлөвлөж буй УТХГН-ийн дэвсгэр нутаг | 11852,0 | 9278,0 |
| 7. | Аялал жуулчлал, рекреацийн бүс газар | 13122,7 | 10498,2 |
| Нийт | | 42305,8 | 34249,1 |

Засгийн газрын Эрчимжсэн мал аж ахуйн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сүүний чиглэлийн суурин фермерийн аж ахуйн хэрэгцээнд 32-42 мян.га байгалийн хашаалсан бэлчээр, 130-150 мян.га тэжээлийн ургамал тариалах талбай, 80-90 мян.га хадлангийн газар шаардлагатай байгаа юм.

Бэлчээрийн доройтлолтой тэмцэх зорилгоор нөхөн сэргээх арга хэмжээнд 2003-2013 онд 5.7 сая га, 2014-2023 онд 7.8 сая га-г хамруулж чадвал нөхөн сэргээлт хийх шаардлагатай бэлчээрийн талбай 22.3 сая га-гаас 6.8 сая га болтлоо буурна.

Доройтсон бэлчээрийг нөхөн сэргээлтэд хамруулах хуваарь /мян.га/

Хүснэгт №7

| Аймгууд | 2002 оны байдлаар нөхөн сэргээлт хийх шаардлагатай талбай | 2003-2013 онд | | | 2014-2023 онд | | |
|-------------|---|----------------------------|-------------------------------|--|----------------------------|-------------------------------|--|
| | | Нөхөн сэргээлт хийх талбай | Шаардагдах хөрөнгө, /сан төг/ | 2013 оны эцэст нөхөн сэргээлт хийх шаардлагатай талбай | Нөхөн сэргээлт хийх талбай | Шаардагдах хөрөнгө, /сан төг/ | 2023 оны эцэст нөхөн сэргээлт хийх шаардлагатай талбай |
| Архангай | 663.4 | 331.7 | 5306.9 | 331.7 | 331.7 | 5306.9 | |
| Баян-Өлгий | 131.5 | 65.8 | 1052.2 | 65.8 | 65.8 | 1052.2 | |
| Баянхонгор | 2623.0 | 655.8 | 10492.0 | 1967.3 | 983.6 | 15738.1 | 983.6 |
| Булган | 1016.8 | 254.2 | 4067.1 | 762.6 | 381.3 | 6100.7 | 381.3 |
| Говь-Алтай | 1276.8 | 319.2 | 5107.4 | 957.6 | 478.8 | 7661.0 | 478.8 |
| Говьсүмбэр | 110.2 | 55.1 | 881.9 | 55.1 | 55.1 | 881.9 | |
| Дархан-Уул | 15.0 | 15.0 | 240.0 | | | | |
| Дорнод | 2100.2 | 525.1 | 8400.8 | 1575.2 | 787.6 | 12601.2 | 787.6 |
| Дорноговь | 0.1 | 0.1 | 1.6 | | | | |
| Дундговь | 1327.3 | 331.8 | 5309.3 | 995.5 | 497.7 | 7964.0 | 497.7 |
| Завхан | 34.9 | 34.9 | 558.4 | | | | |
| Орхон | 12.9 | 12.9 | 206.4 | | | | |
| Өвөрхангай | 1517.3 | 379.3 | 6069.2 | 1138.0 | 569.0 | 9103.8 | 569.0 |
| Өмнөговь | 1144.7 | 286.2 | 4578.8 | 858.5 | 429.3 | 6868.2 | 429.3 |
| Сүхбаатар | 886.1 | 221.5 | 3544.6 | 664.6 | 332.3 | 5316.8 | 332.3 |
| Сэлэнгэ | 30.6 | 30.6 | 489.6 | | | | |
| Төв | 4003.4 | 800.7 | 12810.9 | 3202.7 | 800.7 | 12810.9 | 2402.0 |
| Увс | 7.4 | 7.4 | 118.4 | | | | |
| Ховд | 1251.6 | 312.9 | 5006.4 | 938.7 | 469.4 | 7509.6 | 469.4 |
| Хөвсгөл | 1983.4 | 495.8 | 7933.5 | 1487.5 | 743.8 | 11900.3 | 743.8 |
| Хэнтий | 1994.9 | 498.7 | 7979.7 | 1496.2 | 748.1 | 11969.6 | 748.1 |
| Улаанбаатар | 283.7 | 141.9 | 2269.6 | 141.9 | 141.9 | 2269.6 | |
| Дүн | 22415.3 | 5776.5 | 92424.8 | 16638.8 | 7815.9 | 125054.8 | 8822.9 |

Доройтсон бэлчээрийг өнгөн сайжруулалтын аргаар нөхөн сэргээх нь асар их хэмжээний, ойролцоо үнэлгээгээр нэг га-д 13.8-14.0 мянган төгрөгийн хөрөнгө шаардагдах тул бэлчээрийн менежментийн энгийн аргуудыг малчдын идэвхи, хүч чармайлтад түшиглэн явуулах нь зүйтэй.

Гэхдээ бэлчээрийн мэрэгчид тархсан 10 гаруй сая га-д устгал хийх ажил хууль тогтоомжийн дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэнэ.

Цөлжилтөөс урьдчилан сэргийлэх менежментийн орон нутгийн арга хэмжээнд дараахь бодлогыг баримтална:

- цөлжиж буй нэгж талбарын салхины зонхилох чиглэлийн дээд талд букуу баруун, баруун хойд талаар заг, урт навчит балгана тариалах;
- ашиглаж байгаад орхисон тариалангийн жижиг талбайнуудад заг уржүүлэх.

бэлчээрт гарч байгаа олон салаа замыг цэгцлэх, жолоон нарт анхааруулах тэмдэг, санамж тавих, ухуулга сурталчилгаа хийх, заг болон бутлаг ургамлыг түлшинд хэрэглэхийг зогсоож, говийн малчдын түлшний хэрэгцээг хангах бодлого боловсруулж хэрэгжүүлэх; бэлчээрийн ургамлан нөмрөгийг сэргээхэд сөөг, сөөгөнцөр ургамлууд их үүрэгтэйг анхаарч, зэгс, сөөг, дэрсстэй газрыг хамгаалах, боломжтой газар шим бордоогоор бордох.

Бэлчээрийн талхлагдалтыг багасгах чиглэлээр төрийн болон орон нутгийн иргэд, малчдын хамтарсан менежментийн арга хэмжээнд:

алслагдсан бэлчээрт шинээр худаг гаргах; эвдэрсэн худгуудыг засварлах; бэлчээрийг өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа гэсэн 4 сэлгээгээр ашигладаг горимд эргэж орох.

сумын төвөөс алслагдсан хүн амд эмнэлгийн үйлчилгээг зохион байгуулах; сумын төвөөс алслагдсан хүн амыг телевизор, холбооны хэрэгслээр хангах; бэлчээрийн телбөрийг сум дотроо ялгавартай тогтоож, сумын төвөөс алслагдсан айлуудыг телбөрөөс чөлөөлөх зэрэг нь бэлчээрийг талхлагдалтаас хамгаалах.

Бэлчээр усжуулалт

Бэлчээрийн мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангах гол нөхцөлүүдийн нэг нь усжуулагдсан бэлчээр билээ.

Бэлчээрийн газрын нөөцийг бүрэн ашиглахын тул ойрын 15-20 жилийн дотор бэлчээр усжуулалтын түвшинг 80 хувьд хүргэх шаардлага тулгарч байна.

Худаг засварын ажлын хэмжээ жилээс жилд өсөж, түүнд зарцуулж буй хөрөнгийн хэмжээ ч өсч байгаа юм.

Бэлчээр усжуулалтын ажлыг эрчимжүүлэхийн тулд хэд хэдэн үе шаттай арга хэмжээг жил бүр төлөвлөн хэрэгжүүлэхээр дараахь бодлогыг баримтална.

улсын төсвөөс тодорхой хэмжээний хөрөнгө гаргаж эвдэрсэн худаг, уст цэгийг сэргээж засвар хийх.

гадаад улс, олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлэх төслийн хүрээнд худаг засварлаж, шинэчлэх ажил хийх.

говь, тал хээрийн бүсэд ойрын жилүүдэд шинээр худаг гаргах.

аймаг, орон нутаг иргэд, малчдын оролцоотойгоор гар худаг гаргах ажлыг дэмжиж эрчимжүүлэх гэх мэт.

Бэлчээр усжуулалтын түвшинг дээшлүүлэх нь мал сүргийн усан хангамж сайжирч, бэлчээр нутагт жигд тархан нутаглах ач холбогдолтойгоос гадна малчин өрхүүдийн усан хангамж шийдэгдэх давхар ач холбогдолтой. 2005-2020 онд буюу 15 жилийн хугацаанд ойролцоогоор 10000 шинэ худаг гаргах, үүний дотор говь, хээрийн бүсийн аймгуудын бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах зорилгоор ашиглалтгүй болсон инженерийн хийцтэй 900 уст цэгийг 2010 он хүртэл үе шаттайгаар сэргээн засварлаж, ашиглалтын түвшинг сайжруулах шаардлагатай байна.

Нэн түрүүнд усжуулах бэлчээрийн талбай

Хүснэгт №8

| Бэлчээр усжуулах районууд | Төлөвлөсөн он | Шинээр гаргах худаг | Засварлах худаг | Усжуулах бэлчээр мян.га |
|-----------------------------|---------------|---------------------|-----------------|-------------------------|
| Дорнод монголын хээрийн бүс | 2004-2010 | 1000 | 1000 | 18000.0 |
| | 2011-2015 | 1200 | 2000 | 67000.0 |
| | 2016-2023 | 1500 | 1500 | 29000.0 |
| Дүн | | 2200 | 4500 | 110000.0 |
| Төвийн район | 2004-2010 | 2500 | 1000 | 73000.0 |
| | 2011-2015 | 800 | 2000 | 50000.0 |
| | 2016-2023 | | 2900 | 61900.0 |
| Дүн | | 3300 | 5900 | 194000.0 |
| Хангайн район | 2004-2010 | | 1000 | 26000.0 |
| | 2011-2015 | 1000 | 1800 | 38000.0 |
| | 2016-2023 | 1500 | 1000 | 63000.0 |
| Дүн | | 2500 | 3800 | 160000.0 |
| Монгол ба Говийн Алтайн | 2004-2010 | | 1000 | 31000.0 |
| | 2011-2015 | 250 | 1000 | 39000.0 |
| | 2016-2023 | 1750 | 1100 | 80000.0 |
| Дүн | | 2000 | 3100 | 139000.0 |
| Бүгд | | 10000.0 | 17410.0 | 649610.0 |



Дээрх арга хэмжээнд 65 сая га бэлчээр хамрагдах бөгөөд ингэснээр 2023 оны түвшинд ашиглахар төлөөлж буй нийт бэлчээрийн /118.7 сая га талбайн 86 хувь, Алтайн уулархаг нутаг, говь, тал хээрийн бүсийн бэлчээрийн талбайн 91.3 сая га / 71 хувь нь усжуулагдах бөгөөд дурал №3 байгалийн ил задгай уст цэг, сдос бишгаа усан хангамж нь шийдэгдсэн талбайг оролцуулан тооцвол бэлчээрийн усан хангамжийн суудал үндсэндээ шийдэгдэх юм.

2.1.3. Эрчимжсэн мал аж ахуй ба газар ашиглалт

Одоогоор мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэлтэд хот орчмын сүүний чиглэлийн эрчимтэй фермерийн аж ахуй усалгаагүй ба усалгаатай газар тариалангийн чиглэлийн фермерийн аж ахуй, бэлчээрийн мал аж ахуйн фермер зэрэг чиглэлүүд бий болоод байна. Эдгээр нь мал аж ахуйг эрчимжүүлэх үйлст өөрийн хувь нэмрийг зохих хэмжээгээр оруулах нь дамжиггүй.

Засгийн газрын "Эрчимжсэн мал аж ахуй" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд газар ашиглалтыг оновчтой зохион байгуулах, ялангуяа суурин аж ахуйн хэлбэрээр хөгжих фермерийн болон бусад хэлбэрийн аж ахуйг эзэмшил газраар тогтвортой хангах асуудал чухал үүрэг гүйцэтгэнэ.

"Эрчимжсэн мал аж ахуй" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сүүний чиглэлийн фермерийн аж ахуйн газар эзэмшилт-ашиглалт онцгой анхаарал татна.

Фермерийн эрчимжсэн аж ахуйн бүсүүдийн хөгжлийг дараахь байдлаар авч үзэв:

а/нийслэл хот болон эдийн засгийн бүсүүдийн тулгуур төвүүдийн орчимд суурьшин хөгжих фермерийн аж ахуйн бүс;

б/томоохон хот суурингуудын зах зээлд бүтээгдэхүүнээ нийлүүлэх үүрэг бүхий алслагдсан, таруу байршилтай сүүний чиглэлийн фермерийн аж ахуйн бүсүүд;

в/шинээр үүсэн буй болох олзворлох, боловсруулах үйлдвэржилтийн бүсүүдийн дэргэдэх фермерийн аж ахуйн бичил бүс.

Фермерийн аж ахуйн бүсэд сүүний чиглэлийн жижгэвтэр фермерийн аж ахуйнууд, төмс, хүнсний ногоо тариалдаг жижиг аж ахуйнууд, гахай, тахиа үржүүлдэг аж ахуйнууд орно. Эдгээр салбарууд бүгд өөр хоорондоо цаг хугацаа, хүний болон түүхий эдийн нөөцөөр өрсөлдөх шинжтэй учраас нэг фермийн дотор хослохгүй тус тусдаа нарийн төрөлжих төлөвтэй байна. Тухайлбал, сүүний үхэр, гахай, тахианы салбар нь тэжээлээр өрсөлдөнө. Сүүний үхэр эрхэлдэг аж ахуй намар

хадлан, даршаа бэлтгэх цагаар төмс, хүнсний ногооны хураалт явагддаг тул хөдөлмөрийн нөөц машин, техникээр өрсөлдөнө.

Өндөр ашиг шимтэй сүүний чиглэлийн үхрийн аж ахуй нь өөрийн хэрэгцээг хангахууд хэмжээний эзэмшил газартай байж шаардагдах бэлчээрийн ногоо, шүүц тэжээл ба хадлангийн хэрэгцээг өөрсдөө хангаж, харин шаардагдах хүчит тэжээлийг гаднаас худалдаж авахаар тооцоход 32-42 мян га хашвалсан бэлчээр, 130-150 мян га тариалангийн талбай, 80-90 мян га хадлангийн газар шаардагдахаас гадна фермерийн аж ахуй бүрийн суурьшилд 0.32 га газар олгох шаардлага гарна.

Фермерийн аж ахуйн бүсийн байршил, фермерийн эзэмшил газар, түүний дотоод газар зохион байгуулалт зэрэг асуудал нь аймгийн болон сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний чухал асуудал байх болно.

2.1.4. Хадлангийн газар

Улсын хэмжээгээр хадлангийн газарт бүртгэлтэй 1972 мян га газар байгаа бөгөөд бүрэн ашиглахад 700 мян. тн тэжээлийн нэгжтэй тэнцэх 1610 мян. тн хадлан бэлтгэх нөөцтэй. Малын тоо толгой, түүний тэжээлийн хэрэгцээтэй уялдуулан авч үзвэл дор хаяад 1600 мян га газраас 1270 мян. тн өвс бэлтгэх шаардлагатай. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх болон малын тэжээлийн асуулгын фондыг бүрдүүлэхэд хадлангийн өвс шийдвэрлэх үүрэгтэй. Гэвч хадлангийн газар улсын нийт нутаг дэвсгэрт жигд бус байрласан, малын нягтрал харьцангуй бага Дорнод монголын хээрийн бүсэд их хэмжээтэй байгаа, малын нэмэгдэл тэжээлийн хэрэгцээ ихтэй говийн бүсэд үндсэндээ хадлангийн талбай байхгүй зэрэг нь ихээхэн сөрөг талтай асуудал юм.

Тооцоогоор төлөвлөлтийн эхний 10 жилд Дорнод аймаг, Хэнтийн өмнөд хэсэг, Сүхбаатар аймгийн зүүн ба хойд хэсгийн /газар нутгийн Т-1, Т-2, Т-3 тойргуудын/ хадлангийн талбай, Хөвсгөлийн өмнөд, Архангайн хойд, Булганы баруун хэсгийг хамарсан ХУ-2, Хөвсгөлийн хойд хэсгийг хамарсан ХУ-1, Хэнтийн хойд хэсгийг хамарсан ХУ-9 тойргуудын хадлангийн талбай техник, хүн хүчний нөөцөөс шалтгаалан дутуу ашиглагдана. Дараагийн 10 жилд газар зүйн байрлалаасаа шалтгаалж тал нутгийн Т-1, Т-2, Т-3 тойргуудын хадлангийн талбай бас л дутуу ашиглагдах төлөвтэй байна. Харин бусад бүх тойргийн хадлан бүрэн ашиглагдана гэж үзэв.

2013 он гэхэд сая гаруй га хадлангийн талбайгаас 872.7 мянган тонн, 2023 он гэхэд 1.5 сая гаруй га хадлангийн талбайгаас 1270.7 мян. тонн хадлан бэлтгэх шаардлагатай тооцоо гарав.

Хадлангийн газрын ашиглалтын хэтийн төлөв

Хүснэгт №9

| Газар нутгийн муж тойргийн индекс | | Хадлангийн талбайн нөөц /мян.га/ | Хадах талбай /мян.га/ | | Га-гийн ургац /цн/га/ | | Хадлангийн нийт ургац /мян.тонн/ | |
|--|-------|---|--------------------------|--------|-----------------------------|------|--|--------|
| | | | 2013 | 2023 | 2013 | 2023 | 2013 | 2023 |
| 1 | ХО-1 | 103.9 | 103.9 | 103.9 | 8.0 | 8.0 | 83.1 | 83.1 |
| Хот орчмын нутаг | | 103.9 | 103.9 | 103.9 | | | 83.1 | 83.1 |
| 2 | ХУ-1 | 29.5 | 15.0 | 29.5 | 8.3 | 8.3 | 12.5 | 24.5 |
| 3 | ХУ-2 | 312.3 | 200.0 | 312.3 | 7.9 | 7.9 | 158.0 | 246.7 |
| 4 | ХУ-3 | 10.2 | 10.2 | 10.2 | 7.0 | 7.0 | 7.2 | 7.2 |
| 5 | ХУ-4 | 6.5 | 6.5 | 6.5 | 5.3 | 5.3 | 3.4 | 3.4 |
| 6 | ХУ-5 | 10.2 | 10.2 | 10.2 | 5.4 | 5.4 | 5.5 | 5.5 |
| 7 | ХУ-6 | 66.1 | 66.1 | 66.1 | 9.5 | 9.5 | 62.8 | 62.8 |
| 8 | ХУ-7 | 52.8 | 52.8 | 52.8 | 7.7 | 7.7 | 40.7 | 40.7 |
| 9 | ХУ-8 | 88.0 | 88.0 | 88.0 | 9.3 | 9.3 | 81.9 | 81.9 |
| 10 | ХУ-9 | 288.6 | 150.0 | 288.6 | 8.2 | 8.2 | 123.0 | 236.7 |
| 11 | ХУ-10 | 55.0 | 55.0 | 55.0 | 9.0 | 9.0 | 49.5 | 49.5 |
| Хангай-Хэнтийн уулархаг нутаг | | 919.2 | 653.8 | 919.2 | | | 544.4 | 758.8 |
| 12 | АУ-1 | 3.5 | 3.5 | 3.5 | 6.0 | 6.0 | 2.1 | 2.1 |
| 13 | АУ-2 | 12.8 | 12.8 | 12.8 | 11.0 | 11.0 | 14.0 | 14.0 |
| 14 | АУ-3 | 0.4 | 0.4 | 0.4 | 11.8 | 11.8 | 0.5 | 0.5 |
| Алтайн уулархаг нутаг | | 16.7 | 16.7 | 16.7 | | | 16.6 | 16.6 |
| 15 | УТ-1 | 19.8 | 19.8 | 19.8 | 10.7 | 10.7 | 21.1 | 21.1 |
| 16 | УТ-2 | 2.2 | 2.2 | 2.2 | 13.0 | 13.0 | 2.9 | 2.9 |
| 17 | УТ-3 | 24.4 | 24.4 | 24.4 | 8.4 | 8.4 | 20.5 | 20.5 |
| 18 | УТ-4 | 0.3 | 0.3 | 0.3 | 12.2 | 12.2 | 0.3 | 0.3 |
| 19 | УТ-5 | 0.2 | 0.2 | 0.2 | 7.9 | 7.9 | 0.2 | 0.2 |
| Уулархаг талархаг нутаг | | 46.9 | 46.9 | 46.9 | | | 45.0 | 45.0 |
| 20 | Т-1 | 506.5 | 100.0 | 200.0 | 8.6 | 8.6 | 86.0 | 172.0 |
| 21 | Т-2 | 204.7 | 80.0 | 160.0 | 6.8 | 6.8 | 54.4 | 108.8 |
| 22 | Т-3 | 174.4 | 60.0 | 120.0 | 7.2 | 7.2 | 43.2 | 86.4 |
| Тал нутаг | | 885.6 | 240.0 | 480.0 | 22.6 | 22.6 | 183.6 | 367.2 |
| УЛСЫН ДҮН | | 1972.3 | 1061.3 | 1566.7 | 22.6 | 22.6 | 872.7 | 1270.7 |

Цаг уур хуурайшиж жил дараалан ган тохиолдож байгаа нөхцөлд хөдөө аж ахуйн газрын дотроос хамгийн их сөрөг өөрчлөлтөд нэрвэгдэж байгаа нь хадлангийн талбай юм. Хадлангийн ургамлын бүтцэд нэлээд өөрчлөлт орж байна. Энэ нөхцөлд хадлангийн нөхөн сэргээлт нэн чухал билээ. 2002 оны байдлаар улсын хэмжээгээр нөхөн сэргээлт

хийх шаардлагатай хадлангийн талбай 125 мян га байна.

Хөрөнгө, хүчний байдлаас шалтгаалан эхний 10 жилд 37.9 мян га-д, 2013 он гэхэд 87.1 мян га-д, дараагийн 10 жилд 31.6 мян га-д нөхөн сэргээлт хийвэл 2023 онд нөхөн сэргээлт хийх шаардлагатай хадлангийн талбай 55.5 мянган га болж багасна.

Хадлангийн газрын нөхөн сэргээлтийн төлөвлөгөө /мян га/

Хүснэгт №10

| Аймгууд | 2002* оны байдлаар нөхөн сэргээлт хийх шаардлагатай талбай | 2003-2013 он | | | 2014-2023 он | | |
|-------------|--|---------------------|-------------------------------|--|---------------------|-------------------------------|--|
| | | Нөхөн сэргээлт хийх | Шаардгдах хөрөнгө /сая төг**/ | 2013 оны эцэст нөхөн сэргээлт хийх шаардлагатай талбай | Нөхөн сэргээлт хийх | Шаардгдах хөрөнгө /сая төг**/ | 2023 оны эцэст үлдэх нөхөн сэргээлт хийх шаардлагатай талбай |
| Архангай | 3.4 | 1.2 | 24.0 | 2.2 | 2.2 | 44.5 | |
| Баян-Өлгий | 0.8 | 0.8 | 16.0 | | | | |
| Баянхонгор | 0.7 | 0.7 | 13.0 | | | | |
| Булган | 7.7 | 3.0 | 60.0 | 4.7 | 4.7 | 94.9 | |
| Говь-Алтай | 0.1 | 0.1 | 1.5 | | | | |
| Говьсүмбэр | 0.5 | 0.5 | 9.9 | | | | |
| Дархан-Уул | 0.6 | 0.6 | 11.5 | | | | |
| Дорнод | 56.9 | 12.0 | 240.0 | 44.9 | 8.0 | 160.0 | 36.9 |
| Дорноговь | | | | | | | |
| Дундговь | | | | | | | |
| Завхан | 0.6 | 0.6 | 12.0 | | | | |
| Орхон | 0.1 | 0.1 | 1.8 | | | | |
| Өвөрхангай | 0.4 | 0.4 | 8.6 | | | | |
| Өмнөговь | | | | | | | |
| Сүхбаатар | 10.2 | 4.0 | 80.0 | 6.2 | 4.0 | 80.0 | 2.2 |
| Сэлэнгэ | 12.2 | 4.0 | 80.0 | 8.2 | 4.0 | 80.0 | 4.2 |
| Төв | 3.8 | 2.0 | 40.0 | 1.8 | 1.8 | 35.7 | |
| Увс | 1.7 | 1.2 | 24.0 | 0.5 | 0.5 | 9.5 | |
| Ховд | 1.9 | 1.2 | 24.0 | 0.7 | 0.7 | 13.6 | |
| Хөвсгөл | 2.9 | 1.2 | 24.0 | 1.7 | 1.7 | 34.0 | |
| Хэнтий | 20.2 | 4.0 | 80.0 | 16.2 | 4.0 | 80.0 | 12.2 |
| Улаанбаатар | 0.4 | 0.4 | 7.1 | | | | |
| Дүн | 125.0 | 37.9 | 757.4 | 87.1 | 31.6 | 632.1 | 55.5 |

Байгалийн бэлэн хадлангийн газрын нөөцөд түшиглэхээс гадна Ховд аймгийн Шаргуу, Увс аймгийн Тэс, Бөхмөрөн, Булган аймгийн Баяннуур сумын Шартал, Борбулан, Архангай аймгийн Хашаат сумын Лунгийн хөндий болон Төв, Сэлэнгэ,

Хөвсгөл аймагт түүвэр маягаар хадлангийн газар үндсэн болон өнгөц сайжруулалт хийх замаар улсын болон аймгийн нөөцийн тэжээлийг хэрэглэгчдэд ойртуулах боломжийг ашиглах шаардлагатай байна.

2.2. УСНЫ САН БҮХИЙ ГАЗАР

Гадаргын усны нөөц ба усны сан бүхий газар

Монгол орон 1 км² талбайд ноогдох усны нөөцийн хувьд дэлхийн дунджаас үлэмж доогуур, усны хязгаарлагдмал нөөцтэй орон тул усны

нөөцийг зохистой ашиглах, арвижуулах, бохирдлоос хамгаалах зорилтыг усны сан бүхий газрыг хадгалан хамгаалах, зүй зохистой ашиглах зорилттой хослуулан өөрөөр хэлбэл усыг түүний буй болсон, оршин буй газраар нь дамжуулан хэрэгжүүлэх нь чухал юм.

Гадаргын усны сан бүхий газар /мян.га/

Хүснэгт №11

| Гол хамгаалах бүсийн хамт | Булаг, раваан, хамгаалах бүсийн хамт | Нуурууд хамгаалах бүсийн хамт | Мөнх цас, мөсөн голын талбай | УЦС-ын усан сангийн талбай | Бүгд |
|---------------------------|--------------------------------------|-------------------------------|------------------------------|----------------------------|--------|
| 1202,7 | 97,1 | 1824,4 | 65,9 | 18,6 | 3208,7 |

Усны сан бүхий газарт байгалийн ил задгай уст цэгийн эх авсан газар, усны эрэг орчмын газар, төвлөрсөн усан хангамжийн үүсвэрүүдийн ус хамгаалах болон усны ариун цэврийн хамгаалалтын бүсүүд орох бөгөөд урьдчилсан тооцоогоор усны сан бүхий газрын нийт талбай улсын хэмжээгээр 3208.7 мян.га болж байна. "Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем" хөтөлбөр, "Монгол Улсын эрчим хүчний тогтвортой хөгжлийн стратеги" төлөвлөгөөний дагуу усны эрчим хүчний нөөцийг / зураг 4а/ төлөвлөж буй хэмжээнд ашиглахад усан болон усны барилга байгууламжийн дор нэмж 1 сая 111 мян.га газар шаардгдах буюу усан цахилгаан станцын суурилагдсан 1 кв хүчин чадалд 4.3 га газар зарцуулагдахаар байна. Ингэснээр усны сан бүхий газрын нийт талбай 2023 оны түвшинд 4318.7 мян.га болох төлөвтэй байна. Түүнчлэн олон улсын болон орон нутгийн чанартай усархаг, намгархаг газрын ба хот суурин газруудын төвлөрсөн бохир ус цэвэрлэх байгууламжийн доорхи газрын улсын бүртгэл мэдээлэл хараахан байхгүй байна.

Монгол Улсын нутагт илрүүлж судлан нөөцийг нь үйлдвэрийн зэргээр тогтоосон газрын доорхи цэнгэг, цэнгэгдүү усны 115 орд байгаагийн дотроос Дундговь аймгийн Цагаанцав /нөөц нь 69120 м³/хоног/, Өмнөговь аймгийн Балгасын Улааннуур /нөөц нь 40176 м³/хоног/, Дорноговь аймгийн Борхөөвөр дэх газрын доорхи усны багагүй нөөц бүхий /52595 м³/хоног/ ундрагатай томоохон ордууд нь /зураг №5/ хөдөө аж ахуй, уул уурхай, хүн амын суурьшлын асуудлыг шийдэхэд чухал үүрэг гүйцэтгэх нь дамжиггүй.

Усны сан бүхий газрын ашиглалт, хамгаалалтын төлөвлөлт нь байгалийн уст цэг, газрын доорхи усны орд тус бүрээр хийгдэх онцлогтой тул аймгийн болон сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нарийн тусгах шаардлагатай.

Усны сан бүхий газрын ашиглалт, хамгаалалтын талаар улсын хэмжээнд баримтлах нэгдсэн бодлогод:

1. Усны сан бүхий газар, усны нөөц хоёрыг зохистой ашиглах хамгаалах зорилтыг нэгдмэл байдлаар хэрэгжүүлэх.

2. Усны нөөц, түүний байгалийн тэнцэл, усны чанарыг хамгаалахад усны сан бүхий газрыг ялангуяа, усны эх газар, усны эрэг орчмын газар, усархаг намгархаг газрыг зохистой ашиглах, хамгаалах.

3. Нуур, гол, горхины эргийн дагуу 50 м өргөнтэй, усархаг намгархаг газрын эргэн тойронд 100 м өргөнтэй эрэг орчмын бүс тогтоож зарлах.

4. Усны эх авсан газарт 2-3 км өргөнтэй хамгаалалтын зурвас бүс тогтоож ашиглах, хамгаалах горимыг тогтоож өгөх.

5. Хүн амын усан хангамжийн эх үүсвэрийн үүрэг гүйцэтгэж буй аливаа уст цэгт 100 м-ээс доошгүй өргөнтэй эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоох.

6. Усны эх авсан газар, нуурын эргэн тойрны 5 км, гол, горхины эргийн дагуу 3 км доторхи газрын ой мод, бут сөөг, ургамлан нөмрөгийг хамгаалах горимыг уст цэг болгоноор тогтоож мөрдөх зэрэг асуудлууд орно.

2.3. ОЙН САН БҮХИЙ ГАЗАР

Ойн сан бүхий газрын нөөц Монгол орны ойн сан бүхий газрын нийт талбай 18313.2 мян.га бөгөөд түүний 92.1 хувь буюу 16869.2 мян.га-г ойттой талбай, 7.9 хувь буюу 1446.9 мян.га-г ойн бус талбай эзэлж байна. Ойттой нийт талбайн 13495.4 мян.га буюу 80 хувийг ойгоор бүрхэгдсэн талбай, 3373.8 мян.га буюу 20 хувийг нь ойгоор бүрхэгдээгүй талбай эзэлж байна. Говь, цөлийн бүсэд ургадаг заган ойг хасаж тооцвол ойгоор бүрхэгдсэн талбай 10.7 сая га болно.

2.3.1. Ойн сан бүхий газрын ашиглалт, хамгаалалтын хэтийн төлөв

Ойн сан бүхий газрын ашиглалт нь ойн нөөцийг ашиглах, ойн орчинг ашиглах, ойн дагалт баялгийг ашиглах, ойн газрыг ашиглах гэсэн хэлбэрээр явагдаж байна.

Манай орны ойг нөхөн сэргээх ажлыг мод бэлтгэсэн, түймэр, хөнөөлт шавьж, өвчинд нэрвэгдсэн талбайд голлон анхаарахаас гадна тариалангийн талбайд ойн зурвас байгуулах, хүний амьдрах таатай орчинг бүрдүүлэх, цөлжилтөөс сэргийлэх "ногоон хэрэм", "төгөл ой"-г байгуулах, хот сууринг элсний нүүлтээс хамгаалах зориулалттай "ногоон бүс", темер зам, авто замын хамгаалалтын зурвас, гол, горхи, нуурын эрэг орчмын хөрсийг бэхлэх зурвас байгуулах зэрэг бусад байгаль хамгаалах шаардлагад нийцүүлэн мод, бут сөөг тарих ажлыг ерөнхий төлөвлөгөөний хүрээнд дэс дараалалтай хийхээр төлөвлөв /зураг №6/.

Ойг нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэхийн тул дараахь бодлогыг баримтална:

- ойн ургамалжилтын мужуудад селекцийн үнэлгээ хийж, үрийн хэсгийг тусгаарлах, сайн чанарын үрийн нөөцтэй болох;
- ой бүхий аймаг, сум бүрт шилмэл модыг сонгож, үрийн плантаци байгуулах, бүртгэл

Ногоон хэрэм байгуулах зардлын тооцоо /га-д/

Хүснэгт №12

| № | Хийгдэх ажлууд | Хэмжээ | Шаардагдах хөрөнгө /мян.төг/ |
|------------|---|--------|------------------------------|
| 1 | Хамгаалалтын хашаа барих | га | 700,0 |
| 2 | Газар хагалах, мод тарих нүх бэлтгэх | 3000ш | 175,0 |
| 3 | Модны тарьц, суулгац худалдан авах | 3000ш | 1400,0 |
| 4 | Тарьц, суулгацыг тээвэрлэх | 3000ш | 175,0 |
| 5 | Тарьц тарих, арчилгаа, бордоо, хөрс бэлтгэх | га | 1050,0 |
| ДҮН | | | 3500,0 |

9 сумын нутагт 540 га-д ногоон хэрэм байгуулахад 1890,0 сая төгрөгийн зардал шаардагдана.

Дундговь аймгийн Сайхан-Овоо, Дорноговь аймгийн Зүүнбаян, Хэнтий аймгийн Өндөрхаан, Сүхбаатар аймгийн Баруун-Урт зэрэг газарт тус бүр 70 км урт улсын чанартай салхины хамгаалалтын зурвас байгуулна.

2.3.2. Ойн нөөцийн ашиглалт, хамгаалалтын төлөвлөлт

Ойн нөөцийн 58 хувь нь онцгой болон хамгаалалтын бүсийн ойд хамрагдана. Цаашид Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Улаан тайга /108000 га/, Намнан уул /29600 га/, Булган аймгийн

тооллого явуулах, 2003-2023 онд жил бүр 50-иас доошгүй га талбайд үрийн плантаци бий болгох;

аймаг бүрт мод үржүүлгийн газар бий болгож, санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх, ойжуулах ажилд иргэд, олон нийтийн байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйтныг татан оролцуулах хөдөлгөөн өрнүүлэх урамшууллын систем бүрдүүлэх; ойг нөхөн сэргээх ажилд шинэ технологи нэвтрүүлэх, улсын захиалгат эрдэм шинжилгээний ажлыг өргөтгөх; ойжуулалт, нөхөн сэргээлт хийсэн газрыг ойн байр зүйн зурагт тэмдэглэж, баталгаажуулдаг болох.

Улсын хэмжээгээр нэн даруй нөхөн сэргээлт хийх шаардлагатай 63 сая га ойн талбай байгаагийн 3.8 сая га нь навчит болон шилмүүст ойн, 2.5 сая га нь заг, сөөгт ойн талбай юм.

2003-2023 онд 112.9 мян га шилмүүст, 23.3 мян га заган ойн талбайг нөхөн сэргээхээр төлөвлөсөн бөгөөд говь, хээрийн бүсэд 40-50 м өргөн, 60-100 км урт ногоон хэрэм байгуулах явдал онцгой ач холбогдолтой гэж үзэв.

Бугат сумын Ханжаргалант /60000 га/-ын ой тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдана.

Монгол орны ойн сангийн төлөв байдал, ойн ургамалжилтын төрх, ойн давтагдашгүй өвөрмөц ургах орчны хэв шинж, экологийн онцлог, биологийн төрөл зүйлийг хамгаалах, судлах үүднээс 2005 оноос эхлэн Булган аймгийн Хантай нурууны зарим хэсэг, Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Хонин нуга, Шарлунг орчмын хэсэг ойг улсын хамгаалалтад авч судалгаа шинжилгээ, мониторинг хийж байхаар төлөвлөв.

Ойн мэдээллийн сүлжээ бий болгох, сурталчлах, дэлхийн хэмжээнд мэдээлж байх, ойн төлөв байдлын үнэлгээ хийх систем бүрдүүлэх шаардлагатай.

2.3.3. Ойг хамгаалах арга хэмжээний төлөвлөлт

А/ Ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх

Олон зүйлийн шавьж жил дараалан голломтлон тархаж байгаагаас 40.0 гаруй мян.га талбайн мод шарлаж гандаж, 20 мян.га талбайн модлоо ургамал хатаж хуурайшиж байна. Ойжуулалт, хот тохижуулалтад тарьж байгаа мод, сөөгний үрийн 40-50 хувь нь мөөгөнцрийн халдвартай байна. Нарсны гоц аюултай шотте өвчин 30.0 мян.га ойн талбайд тархаад байна. 3624 га-д авиацикийн аргаар тэмцэх ажлыг гүйцэтгэж үзэхэд уг ойн 98.7 хувь сэргэж, 1.3 хувьд нь үр дүн өгөөгүй байна.

20900 га ойн талбайд тэмцэх ажлыг гүйцэтгэхэд 202 сая төгрөг шаардлагатай.

2.4. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН БҮС ГАЗАР

Дэд бүтцийн хөгжлийн газрын хангамж, хэтийн төлөв

Дэд бүтцийг хөгжүүлэх бүс газар нь үндсэндээ зам, шугам сүлжээний газрын хэлбэрээр төлөвлөгдөж ашиглагдаж байна /Зураг №7/. Иймээс дэд бүтцийг хөгжүүлэх бүс газрын хэмжээ, байршил, бүтэц нь эрчим хүч, зам тээвэр, холбоо, мэдээллийн шугам сүлжээ, хүлээн авах, дамжуулах өртөө, станц зэргийн хөгжлийн хэтийн төлөвтэй шууд хамааралтай.

Дэд бүтцийн хөгжлийн дараахь төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах газрыг төлөвлөж тооцоог хийв:

2.4.1. Эрчим хүчний шугам сүлжээ

Дэд бүтцийн таатай орчин бүрдүүлэх хүрээнд 14 сумын цахилгаан, дулааны шугам, дэд өртөөний барилгын ажлыг үргэлжлүүлэх, шинээр эхлэн барьж 10 сумыг эрчим хүчний төвлөрсөн системд холбох.

Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийг байгуулах хүрээнд:

- баруун эрчим хүчний нэгдсэн систем байгуулах;
- Говь-Алтай аймгийн нутагт Завхан гол дээр 8 мвт хүчин чадалтай Улаанбоомын усан цахилгаан станц барих;
- Ховд аймгийн нутагт орших Чонохарайх гол дээр 12 мвт хүчин чадалтай Дөргөний усан цахилгаан станц барих;

Тайширын усан цахилгаан станцаас Завханы төв Улиастай хүртэл 110 кв-ын 135 км шугам, Говь-Алтай аймгийн төв Алтай хүртэл 35 кв-ын 47 км шугам барих;

- Дөргөний усан цахилгаан станцыг Мянгадын дэд станцтай 220 кв-ын 78 км шугамаар холбох;
- Өвөрхангай аймгийн Баянтээгийн нүүрсний уурхайг түшиглүүлж 12 мвт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барьж Өвөрхангай аймгийн Арвайхээр дэд станцаас Баянтээгийн 110 кв-ын шугам, Баянтээгийн дулааны цахилгаан станцаас Баянхонгор аймгийн төв хүртэл 220 кв-ын свор хэмжээтэй 110 кв-ын шугам барих.
- Орхон гол дээр 100 мвт хүчин чадалтай усан цахилгаан станц барьж, 220 кв-ын шугамаар төвийн эрчим хүчний системд холбох;
- Хөвсгөл аймгийн төвийг төвлөрсөн эрчим хүчээр хангахын тулд Эрдэнэтээс Хөвсгөл аймгийн Мөрөн хүртэл 220 кв-ын хүчдэлтэй 350 км урт шугам тавих;
- Сайншанд-Замын-Үүдийн 110 кв-ын 198 км шугам барих.

Хоёрдугаар үе шат буюу дунд шатны хугацаа /15 жилд/

- Ховд гол дээр Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг үе шаттай барих;
- Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцаас Ховдын Мянгадын 110 кв-ын хүчдэлтэй дэд станц хүртэл 220 кв-ын хүчдэлтэй 62 км шугам татаж, Мянгадын дэд станцыг өргөтгөж барина.
- Орхон гол дээр 100 мвт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц барьж 220 кв-ын шугамаар төвийн эрчим хүчний системд холбоно;
- Дэлгэр мөрөн дээр 8-20 мвт хүчин чадалтай Чаргайтын усан цахилгаан станц барих;
- Төвийн бүсэд Цагаансуварга, Оюутолгой, Шүтээн Уул, Ихшанхайн нурууны зэсийн ордуудыг ашигласан тохиолдолд Тавантолгойн коксжих нүүрсний уурхайг түшиглүүлэн дунд чадлын дулааны цахилгаан станц барьж, Мандалговь, Чойрөг 220 кв-ын шугамаар төвийн эрчим хүчний системд холбох.
- Зүүн бүсэд Багануураас Өндөрхаан-Чойбалсангийн чиглэлд 220 кв-ын хүчдэлтэй 450 км шугам барих;
- Дөргөний усан цахилгаан станц-Улиастайн хооронд 220 кв-ын хүчдэлтэй 450 км шугам татаж баруун бүсийн эрчим хүчний нэгдсэн систем байгуулна. Ингэснээр баруун бүсийн 5 аймгийг холбосон эрчим хүчний нэгдсэн систем байгуулах;

Улаанбаатар-Улиастайн хооронд 400 кв-ын хүчдэлтэй томоохон хүчин чадлын транзит шугам татаж баруун бүсийн эрчим хүчний нэгдсэн системийг төвийн бүсийн эрчим хүчний системтэй холбон Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийг байгуулах, 2003-2008 онуудад 30 гаруй сумыг төвлөрсөн эрчим хүчний системд, 5-15 жилийн хугацаанд төвлөрсөн эрчим хүчний системд 80 гаруй сумыг 6, 10, 15, 35 кв-ын шугамаар холбож цахилгаанжуулах.

Дээр дурдсан арга хэмжээг хэрэгжүүлснээр эрчим хүчний шугам сүлжээний газрын хэмжээ одоогийнхоос эрс нэмэгдэх төлөвтэй байна /Зураг 8/.

Эрчим хүчний шугам сүлжээнд нийт 26567.6 га газар шинээр төлөвлөгдөж байна.

2.4.2. Авто замын сүлжээний хөгжлийн хэтийн төлөв ба газар ашиглалт

Мянганы замын хэвтээ тэнхлэг нь 2595 км урт, босоо тэнхлэгийн нийт урт 4911 км, үүний 10.9 хувь нь хатуу хучилттай, 6.2 хувь нь хайрган, 82.9 хувь нь сайжруулсан шороон зам байна.

Авто замд 30230 га газар нэмэгдэж, нийтдээ 141440 га газар ашиглагдана /Зураг №10/.

Улсын авто замын сүлжээний хөндлөн болон босоо тэнхлэгүүдийн дагуух зурваст байгалийн нөөц баялагтай томоохон орд газрууд хүн амын 77 хувь, төв суурингийн 72 хувь, мал сүргийн 52.9 хувь нутаглах нь улс орны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх өргөн боломжийг нээх юм.

Мянганы замын хэвтээ чиглэл, замын зурвас газрын тооцоо

Хүснэгт №13

| № | Замын чиглэл | Дүн /км/ | Замын зурвас газрын талбай /га/ |
|----|----------------------------|----------|---------------------------------|
| 1 | Улаанбаатар-Лүн | 131.0 | 1310 |
| 2 | Лүн-Дашинчилэн | 94.0 | 940 |
| 3 | Дашинчилэн-Өгийн доод гүүр | 137.0 | 1370 |
| 4 | Өгийн доод гүүр-Батцэнгэл | 61.0 | 610 |
| 5 | Батцэнгэл-Хануйн гүүр | 140.0 | 1400 |
| 6 | Хануйн гүүр-Тариат | 36.0 | 360 |
| 7 | Тариат-Цахиур | 63.0 | 630 |
| 8 | Цахиур-Загастай | 40.0 | 400 |
| 9 | Загастай-Идэр | 129.0 | 1290 |
| 10 | Идэр-Завханмандал | 198.0 | 1980 |
| 11 | Завханмандал-Дөргөн | 220.0 | 2200 |
| 12 | Дөргөн-Эрдэнэбүрэн | 63.0 | 630 |
| 13 | Эрдэнэбүрэн-Өлгий | 218.0 | 2180 |
| 14 | Өлгий-Цагааннуур | 70.0 | 700 |
| 15 | Цагааннуур-Улаан байшинт | 35.0 | 350 |

Зүүн чиглэлийн замын зурвас газрын тооцоо

Хүснэгт №14

| № | Замын чиглэл | Дүн /км/ | Замын зурвас газрын талбай /га/ |
|--------------------|-----------------------|----------|---------------------------------|
| 1 | Улаанбаатар-Өндөрхаан | 340.0 | 3400 |
| 2 | Өндөрхаан-Сүмбэр | 577.0 | 5770 |
| 3 | Сүмбэр-Улсын хил | 43.0 | 430 |
| Зүүн чиглэлийн дүн | | 960.0 | 9600 |

Мянганы замын хэвтээ тэнхлэг нь нийт 2595 км урт бөгөөд Улаанбаатар хотоос баруун ба зүүн чиглэлд хуваагдсан байдалтай. Энэ чиглэлд 1702 км зам шинээр баригдана. 893 км нь одоо ашиглагдаж буй зам бөгөөд сайжруулалтын арга хэмжээнд хамрагдана.

Босоо тэнхлэгийн авто зам нь улс болон бүс нутгийн түвшинд нийгэм эдийн засгийн хөгжлийг

тэтгэх, одоо байгаа болон цаашид гарах магадлалтай авто зам болон өндөр хүчдэлийн шугам даган бий болох томоохон хот суурин газрыг дайруулан хойд, урд хөршийг зэх зээлийн нэгдсэн гарцаар холбох бөгөөд нийт замын урт 4911 км, үүний 10.9 хувь нь хатуу хучилттай, 6.2 хувь нь хайрган, үлдсэн 82.9 хувь нь сайжруулсан хөрсөн ба ердийн шороон зам байна.

**Босоо тэнхлэгийн замын чиглэл,
замын зурвас газрын тооцоо**

Хүснэгт №15

| Замын төрөл | Алтайбулаг- Сүхбаатар Дархан-Улаанбаатар Сайншанд-Замын-Уурт | Эрэнцав-Чойбалсан Баруун-Урт-Бичигт | Бага Итэнг-Төшиг Булган-Хархорин Арвайхээр-Шивээ хурэн | Ханх-Мөрөн- Улаанстай-Алтай- Булгастай | Боржоо-Улаангом- Ховд-Ярзангай | Бүтэд | Эзлэх хувь |
|---------------------------------------|---|--|---|--|-----------------------------------|-------|------------|
| Замын урт, км Үүнээс | 1031 | 711 | 1291 | 1198 | 680 | 4911 | 100 |
| Замын зурвас газрын талбай /га/ | 10310 | 7110 | 12910 | 11980 | 6800 | 49110 | |

Босоо тэнхлэгийн замын хамрагдах хүрээг 200 км-ээр авч үзэхэд Монгол орны нутаг дэвсгэрийн 40.6 хувь, хүн амын 56.8 хувь, малын тоо толгойн 34.3 хувь нь энэ хүрээнд хамрагдаж байна.

Төслийн хүрээнд 4069.6 км зам шинээр барихаас 643 км нь хатуу хучилттай, 3426 км нь хайрган хучилттай байхаар төлөвлөв.

Улсын чанартай авто замд одоогоор 111210 га газар эзэмшигдэж байгаа бөгөөд төлөвлөлтөөр:

- | | |
|-------------------------------|--------|
| 1. Лун-Дашинчилэн | 94 км |
| 2. Дашинчилэн-Өгийн доод гүүр | 147 км |
| 3. Өгийн доод гүүр-Батцэнгэл | 61 км |

- | | |
|-------------------------|--------|
| 4. Батцэнгэл-Хануй | 160 км |
| 5. Цахир-Загастай | 40 км |
| 6. Загастай-Идэр | 139 км |
| 7. Идэр-Завханмандал | 208 км |
| 8. Завханмандал-Дөргөн | 230 км |
| 9. Дөргөн-Эрдэнэбүрэн | 69 км |
| 10. Өндөрхаан-Сүмбэр | 698 км |
| 11. Сүмбэр-улсын хил | 43 км |
| 12. Баянхонгор | 72 км |
| 13. Өмнөговь-Шивээхүрэн | 698 км |
| 14. Дундговь-Говьсүмбэр | 364 км |

гэсэн чиглэлээр 3023 км зам тавигдаж 30230 га газар нэмэгдэж, авто замд нийтдээ 141440 га газар зориулагдана. Энэ нь нутаг дэвсгэрийн 0.09 хувийг эзлэх болно.

**Улсын чанартай авто замд шинээр
төлөвлөгдөж буй газар (аймгаар)**

Хүснэгт №16

| № | Аймгийн нэр | Замын урт (км) | Зурвас газар (га) |
|----|-------------|----------------|-------------------|
| 1 | Архангай | 248 | 2480 |
| 2 | Булган | 260 | 2600 |
| 3 | Баянхонгор | 72 | 720 |
| 4 | Дундговь | 364 | 3640 |
| 5 | Дорнод | 447 | 4470 |
| 6 | Завхан | 450 | 4500 |
| 7 | Өмнөговь | 698 | 6980 |
| 8 | Сүхбаатар | 150 | 1500 |
| 9 | Төв | 48 | 480 |
| 10 | Ховд | 185 | 1850 |
| 11 | Хэнтий | 101 | 1010 |
| | Нийт | 3023 | 30230 |

2.4.3 Төмөр замын сүлжээний хөгжил ба газар ашиглалт

Төмөр замын газар нь төмөр замын зурвас газар болон төмөр замын аюулгүй байдалд зориулан тогтоосон хамгаалалт /аюулгүй/-ын бүсийн газраас бүтнэ. Төмөр замын зурвас газарт өртөө хоорондын болон салбар зам шугам, үйлдвэрлэл

технологийн барилга, төмөр замын холбоо, дохиолол, эрчим хүч, усан хангамж, сүлжээний тоног төхөөрөмж, замын далан, ул шороо, гарам, гүүр, хоолой, хориг хашаа байрлахаас гадна төмөр замын шугамын дагуу тээврийн аюулгүй байдлыг хангах технологийн үйл ажиллагаа явуулахад зайлшгүй шаардлагатай орон зай багтана.

Төлөвлөсөн төмөр замд ашиглагдах газар
Хүснэгт №17

| № | Аймгийн нэр | Замын урт (км) | | Замын зурвас газар (га) | Өртөөний тоо (ш) | Өртөөний газар (га) |
|-------------|-------------|----------------|--------------------------|-------------------------|------------------|---------------------|
| | | Нийт | Үүнээс өртөөний урт (км) | | | |
| 1 | Баян-Өлгий | 288.9 | 14 | 3298.8 | 7 | 420 |
| 2 | Баянхонгор | 487.8 | 24 | 5565.6 | 12 | 720 |
| 3 | Булган | 246.2 | 12 | 2810.4 | 6 | 360 |
| 4 | Говь-Алтай | 424.7 | 20 | 4856.4 | 10 | 600 |
| 5 | Говьсүмбэр | 5.2 | - | 62.4 | - | - |
| 6 | Дорнод | 587.5 | 30 | 6690.0 | 15 | 900 |
| 7 | Дорноговь | 328.1 | 10 | 3817.2 | 5 | 300 |
| 8 | Дундговь | 662.9 | 40 | 7474.8 | 20 | 1200 |
| 9 | Завхан | 475.6 | 24 | 5419.2 | 12 | 720 |
| 10 | Орхон | 12.4 | - | 148.8 | - | - |
| 11 | Өвөрхангай | 491.2 | 24 | 5606.4 | 12 | 720 |
| 12 | Өмнөговь | 754.1 | 38 | 8593.2 | 19 | 1140 |
| 13 | Сүхбаатар | 356.6 | 18 | 4063.2 | 9 | 540 |
| 14 | Төв | 76.3 | 4 | 867.6 | 2 | 120 |
| 15 | Увс | 152.0 | 8 | 1728.0 | 4 | 60 |
| 16 | Ховд | 383.0 | 20 | 4356.0 | 10 | 600 |
| 17 | Хөвсгөл | 557.8 | 30 | 6333.6 | 15 | 1280 |
| 18 | Хэнтий | 168.5 | 8 | 1926.0 | 4 | 240 |
| Нийт | | 6458.8 | 324 | 73617.6 | 162 | 9720 |

Тайлбар: Өртөөний газрыг 2 км урт 300 м өргөнөөр, төмөр замын зурвас газрын өргөнийг 120 м-ээр төлөвлөв.

бөгөөд хэтийн төлөвөөр 6458.8 км урт төмөр зам, 162 өртөөнд нийт 83337.6 га газар, үүнээс өртөөнд 9720 га газар, төмөр замын зурвас газарт 73617.6 га газар нэмж төлөвлөгдөн 114577.0 га газар төмөр замд ашиглагдах болно /Зураг №10/.

Одоо байгаа 1812.7 км урт төмөр зам, түүний 73 өртөөнд 31239.4 га газар ашиглагдаж байгаа

Төмөр замын сүлжээг хөгжүүлэхэд шаардагдах газар (бүсээр)
Хүснэгт №18

| № | Бүсийн нэр | Замын урт (км) | Замын зурвас газар (га) | Өртөөний тоо (ш) | Өртөөний газар (га) |
|-------------|-------------|----------------|-------------------------|------------------|---------------------|
| 1 | Төвийн бүс | 1826.6 | 20815.2 | 46 | 2760 |
| 2 | Баруун бүс | 1724.2 | 19658.4 | 40 | 2400 |
| 3 | Хангайн бүс | 1795.4 | 20464.8 | 48 | 2880 |
| 4 | Зүүн бүс | 1112.6 | 12679.2 | 28 | 1680 |
| Нийт | | 6458.8 | 73617.6 | 162 | 9720 |

Төмөр замын сүлжээний хөгжилд шаардагдах газрын шилжилт хөдөлгөөн (трансформаци)
Хүснэгт №19

| Бүсийн нэр | Аймгийн нэр | Хамрагдах талбай бүгд (га) | Үүнээс | | | | | | |
|------------|-------------|----------------------------|----------------------------|-----|---------|------|----------|-------|---------|
| | | | Тусгай хамгаалалттай газар | | Ойн сан | | Тариалан | | Бэлчээр |
| | | | км | га | км | га | км | га | |
| Баруун бүс | Баян-Өлгий | 3466.8 | 7.5 | 90 | | | | | 200 |
| | Увс | 1824 | | | | | | | |
| | Ховд | 4596 | 25 | 300 | | | 1.6 | 19.2 | 63.8 |
| | Завхан | 5707.2 | | | 1.4 | 16.8 | 10.9 | 130.8 | 337.8 |
| | Говь-Алтай | 5096.4 | | | | | 1.3 | 15.6 | 413.1 |

| | | | | | | | | | |
|-------------|------------|---------|-------|--------|-------|--------|------|--------|---------|
| Хангайн бус | Ховд | 6693.6 | | | 40.6 | 487.2 | 34.1 | 409.2 | 5797.2 |
| | Булган | 2954.4 | 0.6 | 7.2 | 4.2 | 50.4 | 3.0 | 36 | 149.1 |
| | Архангай | - | | | | | | | |
| Төвийн бус | Орхон | 148.8 | | | | | | | |
| | Өвөрхангай | 5894.4 | | | | | | | |
| | Баянхонгор | 5853.6 | | | 15.3 | 183.6 | | | 7771.2 |
| | Сэлэнгэ | - | | | | | | | |
| | Говь | 915.6 | | | | | | | |
| Зүүн бус | Дундговь | 7954.8 | | | | | | | |
| | Говьсүмбэр | 62.4 | | | | | | | |
| | Дорноговь | 3937.2 | | | 22.7 | 272.4 | | | 3664.8 |
| | Өмнөговь | 9049.2 | 125.8 | 1509.6 | 26.5 | 318 | | | 7221.6 |
| | Хэнтий | 2022 | | | | | | | |
| Нийт | Дорнод | 7050 | | | | | 35.9 | 430.8 | 167.8 |
| | Сүхбаатар | 4279.2 | | | | | | | |
| | Нийт | 77505.6 | 158.9 | 1906.8 | 110.7 | 1328.4 | 86.8 | 1041.6 | 25786.4 |

Төмөр замын үндсэн сүлжээг бүрдүүлж буй гол чиглэлүүд нь нутаг дэвсгэр, түүний нөхцөл, нөөц баялгийн ашиглалтад тулгуур ач холбогдолтой юм. Тухайлбал, зүүн талаасаа Дорнод аймгийн нутгаас эхлэн манай орны өмнөд хэсгийг бүхэлд нь хамран Их нууруудын хотгороор дамжин баруун тал Ховд аймгийн нутаг хүртэл өргөн зурвас нутагт жигд тархсан газрын тосны баялаг болон харьцангуй жигд тархсан томоохон нүүрсний орд газрууд, Дорноговийн Цагаансуварга, Өмнөговийн Оюутолгойн зэс зэрэг томоохон бусад ордуудыг ашиглах, аялал жуулчлалыг олон улс, бүс нутгийн түвшинд эрчимтэй хөгжүүлж болох нөөц чиглэл нь тогтоогдсон нутаг дэвсгэр, одоо байгаа болон ирээдүйд буй болох хот сууринг энэ сүлжээнд хамруулахаар тооцов.

Төмөр замын үндсэн сүлжээний шинээр буй болох бүтэц нь дараахь чиглэлүүдээс бүрдэнэ:

1. Төмөр замын хөндлөн тэнхлэг (Дорнод Сүмбэрээс Баруун-Урт, Мандалговь, Баянтээг, Баянхонгор, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Цагааннуураар улсын хил гарах);
2. Эрдэнэт-Мөрөнгийн чиглэл;
3. Зүүнбаян-Оюутолгой, Мандалговь, Гашуунсүхайтын чиглэл;
4. Шивээхүрэн-Баянтээгийн чиглэл;
5. Улиастайн чиглэл (Говь-Алтайн Жаргалан сумын төвөөс Завханы Арцсуурийн боомт хүртэл);

Дор дурдсан үндсэн тэнхлэгийн хүрээнд дараахь чиглэлүүдэд төмөр зам байгуулах нь нэн ач холбогдолтой гэж үзэж байна:

Хөндлөн тэнхлэгийн хүрээнд:

Зүүн хилээс Чойбалсан ортол;
Чойбалсангаас Баруун-Урт;
Баруун-Уртаас Даланжаргалан;
Говьсүмбэрээс Мандалговь;
Мандалговиос Баянтээг;
Баянтээгээс Баянхонгор;

Баянхонгороос Жаргалан /Говь-Алтай/;
Жаргалангаас /Говь-Алтай/ Ховд;
Ховдоос Цагааннуур боомт.

Босоо тэнхлэгийн хүрээнд:

Зүүнбаянгаас Оюутолгой;
Мандалговиос Гашуунсүхайт;
Баянтээгээс Шивээхүрэн;
Арцсууриас Жаргалан /Говь-Алтай/;
Эрдэнэтээс Мөрөн.

Төмөр замын хөндлөн тэнхлэгийн зүүн төгсгөл нь Халх голоор улсын хил гарч улмаар хилээс 25 км-ийн цаана байгаа БНХАУ-ын Рашаантын нарийн төмөр замаар дамжин Түмэн голын төмөр замтай холбогдох боломжтой ба Тамсагбулаг-Чойбалсан-Баруун-Урт-Дундговь-Өвөрхангай-Баянхонгор-Говь-Алтай-Ховд-Баян-Өлгийгөөр дамжин улсын хил гарч улмаар 300 км-т байгаа ОХУ-ын Зыряновск хотын төмөр замтай холбогдох ирээдүйдтэй. Энэ тэнхлэг нь нийт 9 аймгийн нутгаар дайрч байгаа нь төмөр замын дагуухь сум, суурин газруудын төдийгүй хөдөөгийн хүн амын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, бүх төрлийн үйлдвэрлэл үйлчилгээ, худалдаа арилжаа, бизнесийн орчин бүрдүүлэхэд асар их нөлөө үзүүлэх нь дамжиггүй.

Эрдэнэт-Мөрөнгийн төмөр замын сүлжээг байгуулснаар Бүрэнхааны фосфорит, Алаг-Эрдэнийн хөнгөн цагааны ордууд ашиглалтад орж жилдээ 2-2.5 сая тонн баяжмал төмөр замаар тээвэрлэнэ.

Зүүнбаян-Оюутолгой-Тавантолгойн төмөр замын сүлжээг байгуулснаар Тавантолгойн нүүрс, Оюутолгойн зэс-алт, Цагаансуваргын зэс-молибден, Цагаан элс, хойт, урд Төхөм, Эргэл, Галба, Номгоны газрын тосны ордыг ашиглах боломж бүрдэж, жилдээ 1.5-4 сая тонн бүтээгдэхүүн тээвэрлэх болно.

Бор-Өндөр-Баруун-Урт-Чойбалсан-Рашаантын төмөр замын сүлжээг байгуулснаар

Төмөртэйн цайр, Адуунчулууны нүүрс, Буйр, Тамсаг, Матад, Тосон уулын газрын тосны ордыг ашиглах, өргөтгөх боломж бүрдэхээс гадна малын тэжээлийн өвс экспортод гаргах нөхцөл бий болж, жилдээ төмөр замаар 0.9–1.8 сая тонн ачаа тээвэрлэн, улмаар олон улсын "Түмэн гол" төсөлд нэгдэх гол зам үүснэ.

Баруун босоо тэнхлэг буюу Сайхан–Тоорой–Нарийнсухайт–Баянхонгор–Алагийн дөрөлж–Тэсийн төмөр замын сүлжээг байгуулснаар Нарийнсухайт, Баянтээг, Бөмбөгөрийн нүүрсний, Алагийн дөрөлж, Яруугийн фосфорит, Улиастайн төмөр, Асгатын мөнгө-холомог металл, Увсын төмөр, давс, нүүрс, Баянхонгорын Баянбулагийн хөнгөн цагаан, Хар-Ус, Шарга, Богд, Нэмэгт, Онги, Хонгор, Борзонгийн газрын тосны ордыг ашиглах, өргөтгөх боломж бүрдэж жилдээ төмөр замаар 12 сая тонн бүтээгдэхүүн тээвэрлэх, экспортлох нөхцөл бүрдэнэ.

Налайх-Багануурын чиглэл. Энэ чиглэл нь ачаа эргэлтийн дамжин өнгөрүүлэх хурдыг нэмэгдүүлэх стратегийн ач холбогдлоор төлөвлөгдөж байгаа.

Одоо ашиглаж буй төмөр замаар тээвэрлэж буй ачааг тооцолгүйгээр зөвхөн шинээр байгуулах төмөр замын сүлжээгээр голлох томоохон ордуудыг түшиглүүлэн барих уурхайнуудын хүчин чадлаар тооцоход жилдээ 16.4–20.3 сая тонн ачаа тээвэрлэн экспортод гаргах боломж бүрдэхээс гадна уг төмөр замын үйлчлэх хүрээнд улсын нийт хүн амын 55.8 хувь, малын 81.5 хувь хамрагдахаар байна.

2.4.4. Иргэний агаарын тээврийн хэтийн төлөв ба газар ашиглалт

Агаарын зайд нислэг үйлдэх ажиллагааг хэвийн явуулахад тодорхой зориулалтын газрууд шаардагддаг. Эдгээрт агаарын хөлгийг үйлчлэх, байрлуулах, хөөргөх, буулгах явгалахад зориулан усан гадаргуу юмуу хуурай газар тоногдсон аэродром, аэродромын орчмын нутаг дэвсгэр, аэродром ба агаарын тээврийг үйлчлэх нисэх буудал, агаарын замын дагуу байрлуулсан газрын холбооны болон бусад станцуудад олгосон зэрэг газрууд багтана.

Монголын иргэний агаарын тээвэр нь аймгийн төв бусад суурины байнгын 21 нисэх буудал, улирлын чанартай 5 нисэх буудалд ажиллаж эдгээрт 53320 га газар ашиглагдаж байна.

Шинээр Төв аймгийг Хөшигийн хөндий болон Өмнөговь аймагт олон улсын нисэх буудал байгуулахад 1600 га газар шаардагдана.

2.4.5. Холбоо мэдээллийн нэгдсэн сүлжээний хэтийн төлөв ба газар ашиглалт

Ойрын 5 жилд Ховд-Улаангом, Мөрөн-Булганы чиглэлд хуучин агаарын шугамыг ашиглан өндөр хурдны шилэн кабелийн хот хоорондын шинэ сүлжээ байгуулахаар Засгийн газрын мөрийн хөтөлбөрт туссан байна. Эдгээр төлөвлөлт нь хуучин агаарын шугамаар буюу 20 метрийн зурвас газраар хамгаалагдахаар тооцоонд орсон шугамыг ашиглах учир шинээр газар төлөвлөх шаардлагагүй гэж үзлээ.

2008 оноос хойш харилцаа холбооны нэгдсэн сүлжээнд хот хоорондын сүлжээнд технологийн бүрэн шинэчлэлт хийгдэж дуусаад орон нутгийн сүлжээний технологийг шинэчлэх явц давамгайлах болно. Иймд цахилгаан холбооны сүлжээний хот хооронд ба аймаг-сумын хоорондох сүлжээний хамгаалалтын зурвас газрын хэмжээнд онц өөрчлөлт орохгүй бөгөөд харин цаашдаа өнөөдрийн хамгаалалтын зурвасын хэмжээ багасгах хандлага харагдаж байна. Харин байршил, чиглэлд өөрчлөлт орно /Зураг 9/.

2.5 ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БҮС ГАЗАР

Үйлдвэржилтийн бүс газрын хэтийн төлөв

Ойрын 20 жилд ашиглалтад орох магадлалтай дараахь ашигт малтмалын 14 орд газрыг /Зураг 11/ сонгон авч газар ашиглалтыг төлөвлөлтөд тусгалаа.

1. Алт, зэс
Оюутолгойн алт, зэсийн орд Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт 8496 га талбайтай, 3217.5 мян тн цэвэр зэс, 340 тн алтны нөөцтэй;
Цагаансуваргын зэс-молибдены орд 143.3 сая тн хүдэр, 962.7 мян тн зэсийн нөөцтэй, Бороогийн алтны үндсэн орд Сэлэнгэ аймаг Зүүнхараа суманд орших 1407 га талбайтай, алтны балансын нөөц 43 тонн, Олон овоотын алтны үндсэн орд Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын нутагт оршдог В-1075.9 кг алтны нөөцтэй Нийт ашиглагдах талбай 85 га.
2. Цайр:
Төмөртэйн овооны цайрын орд Сүхбаатар аймаг Баруун-Урт сумын нутагт байдаг, 2830 га талбайтай, 1034 мян тн металл цайрын нөөцтэй.
3. Мөнгө:
Асгатын мөнгөний орд Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт оршдог, 2500 га талбайтай, цэвэр мөнгөний нөөц 2247.2 тн.
4. Төмөр:
Төмөртэйн төмрийн орд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт оршдог, 2864 га талбайтай, 158 сая тн төмрийн нөөцтэй.

5. Фосфорид:
Бүрэнхааны фосфоридын орд. Хөвсгөл аймаг Мөрөн сумын нутагт 14000 га талбайтай, 38.8 сая тн фосфорын P_2O_5 /нөөцтэй.

6. Уран:
Хараатын ураны орд Дорноговь аймгийн Чойр сумын нутагт оршдог 2537.5 га талбайтай, 90 мян тн ураны нөөцтэй;
Мардайн ураны орд Дорнод аймаг Баяндун сумын нутагт оршдог, 110 га талбайтай.

7. Нүүрс:
Нарийнсухайтын чулуун нүүрсний орд. Өмнөговь аймаг Гурвантэс сумын нутагт оршдог 2790 га талбайтай, 125.5 сая тн нөөцтэй;
Алаг тогооны чулуун нүүрсний орд. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт /Чойр/ оршдог, 19 га талбайтай, 872 сая тн нөөцтэй.

8. Нефть:
Тамсагбулагийн нефтийн орд. Дорнод аймгийн Тамсагийн сав газарт байрладаг, 124 сая тн түүхий нефтийн нөөцтэй.
Цагаан элсний нефтийн орд. Дорноговь аймаг Сайншанд сумын 5 дугаар багийн нутаг Зүүнбаянд оршдог, 298 сая тн түүхий нефтийн нөөцтэй.

Ойрын 20 жилд шинээр үйлдвэржилтийн дараахь 6 бүс газар үүсэх төлөвтэй байна:

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Оюутолгойн алт, зэсийн орд газрын бүс;
Төв аймгийн Заамар сумын нутаг дахь алтны бүлэг ордын бүс;
Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Төмөртэйн төмрийн ордын бүс;
Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Төмөртэйн овооны цайрын ордын бүс;
Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Алагтогоогийн нүүрсний ордын бүс;
Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийнсухайтын нүүрсний ордын бүс.

Эрдэс баялгийн салбарын хэмжээнд 2010 оны түвшинд төвийн бүсэд 8650, зүүн бүсэд 2100, баруун бүсэд 800, хангайн бүсэд 900 орчим ажлын байр шинээр буй болно. Хөдөлмөрийн нөөцийн тооцоогоор 2010 онд 37400, 2020 онд 50000 хүнтэй 13 суурин шинээр үүснэ.

Орд газруудад байгаль хамгаалах нөхөн сэргээх ажлыг идэвхжүүлэх нь

2001 оны байдлаар 20.1 сая га газарт эрдэс баялгийн хайгуул хийж, 75 мян га газрыг

олборлолтын зориулалтаар ашиглаж байна. Геологи хайгуул, эрдэс баялгийн уурхайн ашиглалтын явцад 10 орчим сая га газар эвдэрсэн буюу доройтсон орчны шинжтэй болжээ.

Өнөөдөр ашигт малтмал ашиглах 527 гаруй лицензээр 94682 га талбай олгогдсон байгаагаас 28000 га талбайд уулын үйлдвэрлэл явагдаж жилдээ дунджаар 86.0 сая м³ газар шорооны ажил гүйцэтгэн 133 сая м³ ус хэрэглэж байгаа тооцоо гарч байна. Нийт хэрэглээний усны 40 хувийг дахин эргүүлж ашиглаж байгааг, мөн түүнчлэн нийт газар шорооны ажлын 35 хувь нь, усны хэрэглээний 70 хувь нь Эрдэнэт үйлдвэр болон нүүрсний уурхайнуудад ноогдож байна. Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын Уул уурхайн кадастрын албанаас гаргасан мэдээнээс үзвэл уурхайнуудад байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажилд жилд дунджаар 1300 сая төгрөг зарцуулж 500 га талбайд нөхөн сэргээх ажил хийж байна.

Ойрын хугацаанд Сэлэнгэ аймгийн Ерөө суманд оршдог Бугантын алтны 22 га, Их-алтатын 10.2 га-д, Шарын голын алтны 900 га-д, Төв аймгийн Заамарын алтны 825 га-д, Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт байдаг Харгуйтын алтны 160 га-д Баянхонгор аймгийн Галуут суманд байрладаг Дөвөнтэйн алтны 220 га-д тус тус уул уурхайн нөхөн сэргээлтийн ажлыг хийхээр төлөвлөвөө.

1999 онд Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар, Байгаль орчны алба хамтран санхүүжүүлж байгаль орчны нөхөн сэргээлтийн стандартуудыг боловсруулж батлуулсан нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд ихээхэн түлхэц болсон. Гэвч уул уурхайн үйлдвэрүүдийн хувьд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх асуудал хурцаар тавигдсан хэвээр байна. Ялангуяа жижиг уурхайнууд нөхөн сэргээлтийн ажлыг орхигдуулж байна. Энэ чиглэлээр дараахь арга хэмжээг авах хэрэгтэй гэж үзэж байна.

байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд зарцуулдаг хөрөнгийн санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох механизм, боловсронгуй болгох, түүний зарцуулалтад тавих олон нийтийн хяналтыг хүчтэй болгох; байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ, байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх ажилд олон нийтийн оролцоо хяналтыг хүчтэй болгох; байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгж, ялангуяа тухайн аж ахуйн нэгжийн эцсийн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэг эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэх; лиценз эзэмшигч байгууллагууд эцсийн тайланг Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын геологийн албанд ирүүлэх хуулийн

заалттай боловч хүлээсэн үүргээ биелүүлээгүй, гүйцэд мэдээлэл ирүүлэхгүй байгаад анхаарах, зохих арга хэмжээ авах; хайгуулын лиценз эзэмшигчид лицензээ нууцлах, буцаах асуудлыг яаралтай мэдэгдэх;

Хот суурин газрын тэг гортиг дотор ажиллаж байгаа үйлдвэр, уурхайнуудын асуудлыг дараахь байдлаар шийднэ:

1. Налайх дүүргийн нүүрсний жижиг уурхайнуудыг хөдөлмөр хамгаалал, аюулгүйн үйл ажиллагааны улмаас 2010 оноос цааш ажиллуулахгүй байх;
2. Улаанбаатар хот орчмын элс хайрганы карьеруудын үйл ажиллагаа нь Туул голын хөндийн усан хангамжийн эх үүсвэрт нөлөөлөх, нийслэлийн байгаль экологид сөрөг нөлөө үзүүлж болзошгүй учраас энэ ордуудыг нийслэл хотоос гаргах, эсхүл тэг гортигоос тэдэн километрээс гадагш байх гэсэн хууль зүйн үндэслэл гаргах;
3. Туул, Хэрлэн, Орхон, Сэлэнгэ гэх мэт томоохон гол мөрний эх, ай сав газруудыг ашиглаж байгаа алтны жижиг ордуудыг хаах.

Уул уурхайн үйлдвэрлэлээс байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөг багасгах асуудалд онцгой анхаарах шаардлагатай байна:

хөрс хуулалт багатай ордууд дээр жилийн газрын задрэлийн 70 хувьтай тэнцэхүйц хэмжээний талбайд нөхөн сэргээлтийн ажлыг хийлгэх;

усны зарцуулалтын судалгаа, нормативыг бий болгон усны бохирдол ба зарцуулалт багатай ажилладаг үйлдвэрүүдийг урамшуулах тогтолцоо бий болгох;

хаягдлын хэмжээг бүртгэлжүүлэх, металл авалтын доод түвшинг тогтоох, хаягдал багатай технологи нэвтрүүлэлтэд татварын хөнгөлөлт болон бусад урамшуулал олгох журамд шилжих;

Монгол Улсад хэрэглэгдэж байгаа болон шинээр оруулж ирж байгаа орчин үеийн олборлолтын аргууд, тухайлбал химийн бодисоор газрын дээр ба гүнд нь уусган олборлох технологийн хувьд байгаль орчныг хамгаалах стандарт, норм,

тэдгээртэй холбогдсон технологийн журам, заавар бий болсон нөхцөлд нэвтрүүлэх.

2.6. ХҮН АМЫН СУУРЬШЛЫН БҮС ГАЗАР

Хөгжлийн чиг хандлага

Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслөөр хотуудын гүйцэтгэх үүргийн хувьд бүсийн төв хот, бүсийн тулгуур төв хот гэсэн ангиллаар авч үзсэн бөгөөд Улсын Их Хурлын чуулганаар баталгаажих түвшинд 8 хотыг "бүсийн төв" статусаар баталсныг төлөвлөлтөд үндэслэв.

Улсын хэмжээнд хөгжлийн нутаг дэвсгэрийн тогтолцоо нь эдийн засгийн бүс, аймаг бүсчлэгдсэн сум, сум гэсэн хэлбэртэй, харин суурьшлын тогтолцоо нь улсын нийслэл, эдийн засгийн бүсийн төв, аймгийн төв, сум дундын тулгуур төв, сумын төв, бусад суурин гэсэн хэлбэртэй байна /Зураг №12/.

Улсын хэмжээнд нийт 99 сууринг үүргийн хувьд тэргүүлэх чиглэлтэй байхаар тооцоолсон бөгөөд үүнээс нийслэл хот, бүсийн болон аймгийн төвийн 23, сум дундын төвийн үүрэгтэй 76 суурин байна.

Одоогоор сум, аймгийн төвөөс гадна үйлдвэр, уурхай, төмөр зам даган хөгжсөн нийт 66 суурин байгаагаас томоохон хот, төмөр зам, амрагт даган хөгжсөн 24, үйлдвэр даган хөгжсөн 30, уурхай даган хөгжсөн 12 тус тус байна.

Налайх, Багануур, Багахангай, Бор-Өндөр, Хөтөлөөс бусад нь 300-гаас доош хүн амтай, 70-аас доош өрхтэй байна. Цаашид хөгжин өргөжих 12 суурин байгаагаас хамгийн том нь Оюутолгойн орд газрыг түшиглэн буй болох юм.

Эдийн засгийн чөлөөт бүсийг Улаанбаатар, Алтанбулаг, Замын-Үүд, Цагааннуур, Багахангайд байгуулах бөгөөд эхний ээлжинд Алтанбулагт 520 га, Замын-Үүдэд 840 га талбайг чөлөөт бүс байгуулахад тохиромжтой гэж үзэж байна. Үйлдвэрийн чөлөөт бүсэд 1500-2500 га байх нь тохиромжтой гэж үзэв.

Хот суурины хөгжилд дэд бүтэц шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд Мянганы замын хөндлөн тэнхлэгийн дагуу хоёр талаараа 200 км үйлчлэлийн хүрээнд нийт 245 суурин хамрагдаж байгаа бөгөөд үүнээс зам дагасан нь 40 суурин, босоо тэнхлэгийн дагуу 79 суурин шууд хамрагдаж байна.

2.7. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ХҮН АМЫН БАЙГАЛЬ-ЭКОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН БҮС ГАЗАР

Төлөвлөлтөд монгол оронд аялал жуулчлал, амралт сувиллыг үндсэн 9 бүсэд хуваан төвлөрүүлж, бүх нутгаар хөгжүүлэхээр тусгасан /Зураг №13/.

Аялал жуулчлал, амралт сувиллын бүс нутгуудын хөгжлийн хэтийн төлөв

Рекреацийн үндсэн бүсүүдэд нөөц болж ашиглагдах газар

Хүснэгт №20

| № | Бүсийн нэр | Нийт талбай /га/ | Ашиглаж байгаа газар /га/ | Шинээр нэмэгдэх талбай /га/ |
|---|----------------|------------------|---------------------------|-----------------------------|
| 1 | Төвийн | 506870,0 | 274,0 | 136,0 |
| 2 | Сэлэнгэ-Дархан | 195000,0 | 112,0 | 28,3 |
| 3 | Мандалговь | 1012500 | 68,2 | 78,0 |
| 4 | Өмнөговь | 1017500 | 80,9 | 61,0 |
| 5 | Дорноговь | 507500 | 61,2 | 8,0 |
| 6 | Хэнтий | 780000 | 70,5 | 48,0 |
| 7 | Дарьганга | 917 | 6,0 | 40,0 |
| 8 | Дорнод | 1387500 | 6,0 | 109,0 |
| 9 | Хангай | 1131350 | 247,8 | 83,5 |
| | Дүн | 6539137,0 | 420,6 | 591,8 |

Аялал жуулчлал, амралт сувилал, зугаалга төлөвлөхийн тулд аялал жуулчлалын үндсэн зэрэг хүн амын рекреацийн зориулалтаар газрын бүсүүдийг дотор нь дэд ба бичил бүсүүдэд нөхцөл нөөцийг ашиглах боломжийг үнэлэн дүгнэж хувааж үзлээ /Зураг №14/.

1. Төвийн бүс

А. Улаанбаатар орчмын дэд бүс

Хүснэгт №21

| Бичил бүсүүд | Талбай /га/ | Ашиглагдаж байгаа /га/ | Шинээр ашиглагдах /га/ | Аялал жуулчлал, амралт сувиллын объектын тоо | |
|--|-------------|------------------------|------------------------|--|----------------|
| | | | | Одоо байгаа | Нэмж байгуулах |
| Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар | 75000 | 62,45 | | 36 | |
| Богд хан уул дархан цаазат газар | 34600 | 28,5 | | 16 | |
| Сэлбэ голын сав | 13600 | 31,2 | 3,5 | 14 | 3 |
| Баянзүрх уул-Гачууртын | 29100 | 7,5 | 7,5 | 5 | 5 |
| Толгойт-Баянголмын сав | 6800 | 24,5 | | 5 | |
| Сонгинохайрхан-Туул голын | 15000 | 10,0 | 12 | 3 | 2 |
| Дүн | 174000 | 164,15 | 23 | 79 | 10 |

Б. Төв аймгийн дэд бүс

| Бичил бүсүүд | Талбай /га/ | Ашиглагдаж байгаа /га/ | Шинээр ашиглагдах /га/ | Аялал жуулчлал, амралт сувиллын объектын тоо | |
|--|----------------|------------------------------|------------------------------|--|-------------------|
| | | | | Одоо байгаа | Нэмж байгуулах |
| Хустайн нуруу байгалийн цогцолборг газар | 50620 | 7,5 | | 7 | |
| Сөгнөгөр-Баянголхн сав | 55000 | 30 | | 7 | |
| Ар,Өвөр Жанчивлан | 32000 | 56,5 | | 2 | |
| Дугана хад-Ел хад | 35000 | 9 | | 3 | |
| Хан Хэнтийн дархан цаазат газар | 127500 | | 28,25 | | 1 |
| Ээж хад | 32750 | 5 | 84,78 | 1 | 3 |
| Дүн | 332870 | 110 | 113,03 | 20 | 4 |

В. Шинээр рекреацийн ашиглалтад оруулах бичил бүс газрууд

| Бичил бүсүүд | Талбай /га/ | Ашиглагдаж байгаа /га/ | Шинээр ашиглагдах /га/ | Аялал жуулчлал, амралт сувиллын объектын тоо | |
|--|----------------|------------------------------|------------------------------|---|-------------------|
| | | | | Одоо байгаа | Нэмж байгуулах |
| Батхаан уулын байгалийн нөөц газар | 58800 | | 32 | | 2 |
| Дэлгэрхангай- Бүрэнгийн бүс | 172000 | | 30 | | 2 |
